TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



# ЖИЛИЙН ТАЙЛАН 2012

ЖИЛИЙН ТАЙЛАН

# 2012

# АГУУЛГА


**Ерөнхийлөгчийн мэндчилгээ** **4**

**Гүйцэтгэх захирлын зурвас** **6**

**Санхүүгийн үзүүлэлтүүд** **8**

**Худалдаа, хөгжлийн банк-2012 онд** **8**

- **Онцлох үйл явдлын товчоон** **9**

  Бидний бахархах олон үйл явдлаас 9-ийг товчлон онцоллоо

- **Нийгмийн хариуцлага** **10**

  Нийгэмдээ санаа тавьдаг, нийгмийн хариуцлагатай байх нь бидний үүрэг

- **Дэлхийд үнэлэгдсэн шагналууд** **11**

  Дэлхий дахинд Монгол улсын ХХБанк онцгойрон үнэлэгдэж, олон улсын хэмжээний шагнал урамшууллыг байнга хүртдэг

**Компанийн засаглал** **12**

- Компанийн засаглалын бүтэц 12
- Төлөөлөн удирдах зөвлөл 12
- Удирдлагын баг 13

**Бизнесийн чиглэлээр хийгдсэн томоохон ажлууд**

- Байгууллагын банкны бизнес 14
- Иргэдийн банкны бизнес 17
- Олон улс, гадаад харилцаа, хамтын ажиллагаа 20
- "Ти Ди Би Капитал" ХХК 22
- Хөрөнгө зохицуулалтын удирдлага 24

**Үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн томоохон ажлууд**

- Эрсдэлийн удирдлага 26
- Мэдээллийн технологийн удирдлага 28
- Хүний нөөцийн удирдлага 30

**Гадаад худалдааны санхүүжилтын гол харилцагч банкууд** **32**

**Ностро дансTай банкууд** **33**

**Аудитын тайлан** **34**

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



## РАНДОЛФ **КОППА**

**ЕРӨНХИЙЛӨГЧ**

2013 оны эхэнд Монгол улсын санхүүгийн салбарын тэргүүлэгч банк болж, эх үүсвэр болон хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэн ажиллалаа. Банкны энэхүү амжилтад хүрэхэд нөлөөлсөн томоохон хүчин зүйлүүд бол олон улсын зах зээл дээрх хөрөнгө оруулагчид болон зээлдэгчдийг татах олон жилийн ашигт ажиллагаа болон Банкны өндөр нэр хүнд юм.

# Эрхэм хүндэт харилцагч, хамтран ажиллагч түншүүд, хувьцаа эзэмшигчид ээ,

Өнгөрөгч 2012 он ХХБ-ны хувьд томоохон онцлох үйл явдлуудаар дүүрэн тэмдэглүүштэй жил боллоо. Монгол улсын эдийн засаг хоёр оронтой инфлиацийг бууруулах арга замуудыг эрэлхийлж, дэлхийн эдийн засаг дахь нүүрсний үнийн бууралтаас шалтгаалсан экспортын бууралт, Хойд Америк, Европ, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төвшин саарсан зэрэг олон хүндрэл давхацсан энэ нөхцөл байдалд ХХБ маш амжилттай ажиллаж, банк байгуулагдсанаас хойших өөрийн түүхэн дэх хамгийн дээд ашигт ажиллагааны төвшинд хүрсэн юм.

Түүнчлэн 2013 оны эхэнд Монгол улсын санхүүгийн салбарын тэргүүлэгч банк болж, эх үүсвэр болон хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэн ажиллалаа. Банкны энэхүү амжилтад хүрэхэд нөлөөлсөн томоохон хүчин зүйлүүд бол олон улсын зах зээл дээрх хөрөнгө оруулагчид болон зээлдэгчдийг татах олон жилийн ашигт ажиллагаа болон Банкны өндөр нэр хүнд юм.

2012 оны 1 дүгээр сард ХХБ нь өөрийн 4.78 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг Голдман Сакс байгууллагад амжилттай арилжаалсны үр дүнд 2012 оны хуримтлагдсан ашиг 63.1 тэрбум төгрөгт хүрснээс гадна нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, цэвэршүүлсэн активын харьцаа 8.18%-иас 9.97% болж өссөн байна.

Мөн онд ХХБ нь хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Голланд улсын Хөгжлийн Банк (FMO)-тай хамтран ажиллаж, 5 жилийн хугацаатай 10 сая ам. долларийн хоёрдогч өглөгийн санхүүжилтийн гэрээг байгуулж, өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын харьцааг өмнөх оны 12.67%-иас 15.12% хүртэл нэмэгдүүлж чадсан байна.

ХХБ-ны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн алдар нэрийг улам бататгаж, төлөвлөгөөт 700 сая ам. долларийн евро-богино хугацаат бондын хөтөлбөрийн хүрээнд 300 сая ам.долларийн бондыг 3 жилийн хугацаатайгаар арилжаалсан. Энэ нь 2007 оноос хойш олон улсын зах зээлд өөрийн EMTN програмыг амжилттай ашигласан дөрөв дэх тохиолдлыг тэмдэглэсэн түүхт үйл явдал байлаа.

Монгол улсын арилжааны банкуудаас ХХБ нь олон улсын зах зээлээс санхүүжилт амжилттай босгож, өөрийн санхүүжилтийн чадавхийг нэмэгдүүлж чадсан цорын ганц банк юм. Тус санхүүжилтийн үр дүнд бид өөрийн харилцагч, түншүүдэд шаардлагатай санхүүгийн хэрэгслүүдийг санал болгон ажиллаж байна.

Гадаад болон дотоодын зах зээлд идэвхтэй оролцож байсан арвин их туршлага нь ХХБ-ны охин компани болох TDB Capital ХХК Монгол улсын эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилготой 1.5 тэрбум ам.долларийн Чингис бондын зөвлөх, андеррайтераар оролцож, олон улсын томоохон санхүүгийн байгууллагуудтай хамтран гаргах томоохон нэр хүнд бүхий ажлыг гүйцэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэлээ.

ХХБ нь Монгол улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулан тэргүүлэгч байр суурийг улам бататган, олон улсад нэр хүндтэй санхүүгийн мэдээллийг хүргэдэг "Bloomberg Media" телевизтэй хамтран "Bloomberg TV Mongolia" телевизийг үүсгэн байгуулж, Монголдоо санхүүгийн болон бизнесийн орчны мэдээ мэдээллийг албан ёсоор цацаж эхэлсэн юм. Энэ нь дэлхий даяар Монгол улсад өрнөж буй үйл явдлыг чих тавин чагнаж буй хөрөнгө оруулагчдад үнэ цэнэтэй санхүүгийн мэдээ мэдээллийг үнэн бодитоор хүргэж буй өндөр ач холбогдолтой үйл ажиллагаа болсон юм.

Мөн Монгол улсын Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сайжруулах хууль, эрхзүйн таатай орчныг бий болгох, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татах онц шаардлагатай байгаа энэ үед хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрийг оруулж байгаа нь ХХБ-ны хувьд нэр төрийн хэрэг юм.

Энэхүү жилийн тайланд байгаа мэдээллүүд нь уншигч танд ХХБ-ны 2012 оны ололт амжилтууд болон санхүүгийн позиц, мэдээ мэдээллийн талаар илүү дэлгэрэнгүйгээр сонордуулна гэдэгт итгэж байна. Өнгөрсөн жилийн хугацаанд амжилт ололт бүхэнд бидэнтэй хамт байж, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхийг зорьж ажилласныг үнэнчээр дэмжиж ирсэн нийт харилцагч, гадаад дотоодын түншүүддээ халуун талархал илэрхийлье.

Хэдийгээр эдийн засгийн болон санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан олон сорилтууд бидэнтэй мөр зэрэгцэн алхаж байгаа ч ирж буй он бидний хувьд өөдрөг, боломжийг дагуулсан онцгой жил байна гэдэгт итгэж байна. Таны итгэлийг дээдэлсэн ХХБ-ны хүндтэй харилцагч, бизнесийн түншүүд, хөрөнгө оруулагчид Та бүхний бизнесийн ашиг орлого өөдөө, амьдрал тань улам цэцэглэн хөгжихийг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,



**Рандолф КОППА**
Ерөнхийлөгч

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗУРВАС



**БАЛБАРЫН МЭДРЭЭ**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Бид монгол хүн бүрт хүргэх зорилготой дэлхийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт санхүүгийн үйлчилгээ болох гар утсаараа банкны төлбөр тооцоог гүйцэтгэдэг Most money үйлчилгээг 2012 оны 9-р сард нэвтрүүлж, дөрөвхөн сарын дотор 15,700 харилцагч Most money үйлчилгээг өдөр тутамдаа идэвхитэй ашигладаг болоод байна.

# ХХБ-ны хувь нийлүүлэгч, бизнесийн түншүүд, хүндэт харилцагчид болон энэхүү тайланг дэлгэн уншиж буй эрхэм Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Бидэнд сорилт, амжилт, өндөр үр дүнг аль алиныг дагуулсан 2012 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа танилцуулж буйдаа туйлын таатай байна.

Өнгөрөгч онд Монгол улсын эдийн засаг нь уул уурхайн салбараар дамжуулан гадаад эдийн засаг, тэр дундаа Хятад улсаас хүчтэй хамааралтай болохыг харуулсан жил боллоо. Урд хөршийн эдийн засгийн өсөлтийн удаашралт нь нүүрсний экспортоос ихээхэн хамааралтай Монгол улсын хувьд 2012 оны 7,8-р сарuудад экспортод огцом нөлөөлж, гадаад худалдааны алдагдлыг эрс нэмэгдүүлсэн юм.

Яг энэ сорилтын үед Монгол улсын Засгийн газраас "Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрүүд"-ийг батлсны дагуу ХХБ "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS" дэд хөтөлбөрийн хүрээнд шатахуун импортлогч үндэсний компаниудад нийт 35,3 тэрбум төгрөг, "Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийн хүрээнд үндэсний үйлдвэрлэгчдэд нийт 17,4 тэрбум төгрөгний зээлийг тус тус олгож, Засгийн газрын бодлогыг дэмжин, эдийн засгийнхаа өсөлтийг нэмэгдүүлэх зорилго өвөртлөн ажиллалаа.

Мөн улсынхаа эдийн засагт томоохон хувь нэмэр, бүтээн байгуулалтыг бий болгодог бидний асар их хүч хөдөлмөрөөр бүтдэг Бондоо олон улсад 3 дахь удаагаа арилжаалснаар үндэсний компани, корпорациудийн бүтээн байгуулалтаа босгоход шаардлагатай санхүүжилтийг олгож, айл гэрийн амин чухал хэрэгцээ болох орон сууцны зээлийг зах зээл дээрх хамгийн бага хүү, мөн хамгийн бага урьдчилгаа бүхий нөхцлөөр бүх салбаруудаараа шуурхай олгосон нь харилцагчдын талархлыг хүлээлээ.

Бид монгол хүн бүрт хүргэх зорилготой дэлхийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт санхүүгийн үйлчилгээ болох гар утсаараа банкны төлбөр тооцоог гүйцэтгэдэг Most money үйлчилгээг 2012 оны 9-р сард нэвтрүүлж, дөрөвхөн сарын дотор 15,700 харилцагч Most money үйлчилгээг өдөр тутамдаа идэвхитэй ашигладаг болоод байна. Цаашид бид Монголын бүх үүрэн холбооны компаниудтай хамтран, Most money үйлчилгээний цар хүрээг улам тэлж, гар утастай хүн бүр байнгын хэрэглээ болгон ашиглаж, банкны үйлчилгээг хялбар, шуурхай хүртээсэй хэмээн хүсч, эрмэлзэн ажиллаж байна.

Монгол улсын нэрийн хуудас болох Үндэсний ₮ картыг Монголбанк зах зээлд нэвтрүүлэн хоногшуулах эхний алхамаа ХХБ-аар эхлэж, анхлан харилцагчиддаа хүргэх банкаар манай банк сонгогдсон юм. Энэ нь банкны салбарт анх удаа төлбөрийн картын зах зээлийг бий болгох, бэлэн бус төлбөр тооцоог эх орондоо хэвшүүлэх ХХБ-ны нөр их хүчин чармайлтыг үнэлсэний илрэл хэмээн бид ₮ картыг хүндэтгэлтэйгээр хүлээн авч, харилцагчиддаа хүргэлээ.

Дэлхийн бүх улс орнууд, томоохон банкуудын хэрэгжүүлдэг мөнгө угаалтын эсрэг тэмцэх олон улсын хууль, дүрэм журмыг сахиж мөрдөх программыг олон улсын зөвлөх байгууллагатай хамтарч, Монголд анх удаа бодлого стратегийн түвшинд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн банк болж чадлаа. Байгаль орчин, нийгмийн хариуцлагын стандартыг олон улсын тввшинд мөн л анх удаа нэвтрүүлснээс гадна дотоод хяналтын матриц буюу банкны бүх эрсдлийг бууруулахын тулд дотоод дахь нийт үйл ажиллагаандаа хяналтын тввшинг тогтоосон томоохон ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

1990 онд бид Байгууллагын соёл хэмээх ойлголтыг банкиндаа нэвтрүүлж эхлэж байсан бол өнөөдөр TDB соёл нэгэнт бие даасан томоохон ойлголт болон хөгжиж, ХХБ-нд ажилладаг хүн бүрт зөв хүн байх бичигдээгүй дадал зуршлыг бий болгодог нь ХХБ банкны салбарт тэргүүн зэргийн банк байж чаддагтай шууд холбоотой хэмээн миний бие бахархдаг юм.

2013 онд ХХБ салбар, сүлжээгээ тэлж, цаг хугацаатай өрсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам чанаржуулах, дэлхийн жишигт хүрсэн олон бүтээгдэхүүнийг дахин бий болгох зорилтыг тавин ажиллахын сацуу дотооддоо "Бүтээмжийг дээшлүүлэх жил" болгон зарлаж, бага цаг хугацаанд үр дүнтэй, өндөр амжилтыг харуулах болно .

Та бүхэн эрүүл энх байж, зөв бодол, чин шударгаар амжилтын өөд тэмүүлж, цог золбоотой байхын ерөөлийг өргөн дэвшүүлэхийн ялдамд ХХБ-ны удирдлагын баг, нийт захирлууд, ажилтнуудаа шаргуу хөдөлмөрсөнд нь талархал илэрхийлье.

2013 он бидний хувьд өөдрөг, гялалзсан амжилтаар дүүрэн жил байх болно.

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн,

**Балбарын МЭДРЭЭ**
Гүйцэтгэх захирал

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ТАЙЛАН ТЭНЦЭЛ

тэрбум төгрөг

| | 2012 он | 2011 он | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь |
| Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө | 444.8 | 475.0 | (30.2) | -6.3% |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 459.2 | 346.5 | 112.6 | 32.5% |
| Зээл ба урьдчилгаа (цэвэр) | 1,533.3 | 1,123.3 | 409.9 | 36.5% |
| Бусад хөрөнгө | 263.2 | 175.9 | 87.3 | 49.6% |
| **Нийт актив** | 2,700.5 | 2,120.7 | 579.7 | 27.3% |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 1,402.3 | 1,277.3 | 125.0 | 9.8% |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 269.5 | 209.4 | 60.0 | 28.7% |
| Гаргасан өрийн бичиг | 600.5 | 207.1 | 393.4 | 189.9% |
| Бусад өр төлбөр | 188.3 | 287.4 | (99.2) | -34.5% |
| **Нийт пассив** | 2,460.6 | 1,981.3 | 479.3 | 24.2% |
| **Өөрийн хөрөнгө** | 239.9 | 139.4 | 100.5 | 72.1% |
| **Нийт пассив ба өөрийн хөрөнгийн дүн** | 2,700.5 | 2,120.7 | 579.7 | 27.3% |

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

тэрбум төгрөг

| | 2012 он | 2011 он | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь |
| Хүүний орлого | 213.3 | 143.5 | 69.8 | 48.7% |
| Хүүний зардал | (137.4) | (95.4) | (42.1) | 44.1% |
| **Хүүний цэвэр орлого** | 75.9 | 48.1 | 27.8 | 57.7% |
| Шимтгэл хураамжийн цэвэр орлого | 16.4 | 12.1 | 4.3 | 35.2% |
| Үйл ажиллагааны бусад орлого (цэвэр) | 14.3 | 14.2 | 0.1 | 0.9% |
| **Хүүний бус цэвэр орлого** | 30.7 | 26.3 | 4.4 | 16.7% |
| **Үйл ажиллагааны орлого** | 106.6 | 74.5 | 32.2 | 43.2% |
| Үйл ажиллагааны зардал | (32.9) | (20.1) | (12.8) | 63.8% |
| Үнэ цэнийн бууралтын (алдагдал) ба нөхөлт | 6.6 | (3.1) | 9.6 | -313.4% |
| **Татварын өмнөх ашиг** | 77.9 | 51.4 | 26.6 | 51.7% |
| Орлогын татварын зардал | (14.8) | (9.3) | (5.5) | 59.6% |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | 63.1 | 42.1 | 21.0 | 49.9% |

## ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

тэрбум төгрөг

| | 2012 он | 2011 он |
|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 26.3% | 30.2% |
| Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (ROAE) | 31.9% | 39.8% |
| Активын өгөөж (ROA) | 2.3% | 2.0% |
| Дундаж активын өгөөж (ROAA) | 2.8% | 2.6% |
| Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь | 1.4% | 2.5% |
| ЗТУБЭХСан/ Чанаргүй зээл | 61.1% | 63.6% |
| Зээл/Харилцах, хадгаламж | 110.3% | 89.3% |
| **Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд** | **2012 он** | **2011 он** |
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, цэвэршүүлсэн активын харьцаа (>8%) | 9.97% | 8.18% |
| Өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын харьцаа (>13%) | 15.12% | 12.67% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (>25%) | 37.00% | 42.00% |
| Нэг зээлдэгчид олгосон зээл, өөрийн хөрөнгийн харьцаа (<20%) | 17.08% | 19.28% |
| Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, өөрийн хөрөнгийн харьцаа (<8%) | 0.13% | 0.14% |

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН


















## 2012 ОНД ДОТООД, ГАДААДЫН ЗАХ ЗЭЭЛД ХИЙЖ, БҮТЭЭСЭН АЖЛУУДААС 9-ИЙГ ТОВЧЛОН ОНЦОЛЛОО

**1.** Монгол улсаас анх удаа олон улсад бондоо арилжаалсан нэр хүндээ дахин баталгаажуулж, 2012 онд 3 дахь удаагаа 300 сая ам.долларын бонд арилжаалсан нь мөн л Монголын аж ахуйн нэгжүүдээс анхны тохиолдол байлаа.

**2.** ХХБанк нийт хөрөнгийн хэмжээгээрээ Монголын хамгийн том банкны байр суурийг эзлэж, 2012 оны эцэст нийт хөрөнгө 2.7 их наяд төгрөг, зээлийн багц 1.5 их наяд төгрөг, дундаж активын өгөөж 2.8 хувьд хүрсэн нь дотоодын банкуудын хамгийн сайн чанар бүхий санхүүгийн үзүүлэлт юм.

**3.** 144 жилийн түүхтэй, Goldman Sachs банк ХХБ-ны 4.8 хувьтай тэнцэх хувьцааг худалдан авч буйгаа дэлхий нийтэд зарласан нь хамгийн ирээдүйтэй, урт удаан, тогтвортой үйл ажиллагаатай бизнест хөрөнгө оруулалт хийдэг Goldman Sachs банкны сонголт бидэнд илүү өндөрлөгт хүрэх, ихийг бүтээх урам өгсөн юм.

**4.** Засгийн газрын Чингис бондын зөвлөх, андеррайтер банкаар ХХБанк Монгол улсаас шалгаран оролцож, дэлхийн хамгийн шилдэг дөрвөн банктай хамтран бондын арилжааны хамтран зохион байгуулагчаар ажиллалаа.

**5.** ХХБанк, "Bloomberg media" групп хамтран Монголын телевизийн түүхэнд цоо шинэ өнгө төрх бүхий санхүү, эдийн засгийн төрөлжсөн суваг "Bloomberg TV Mongolia" телевизийг үүсгэн байгуулж, телевизийн анхны эфир цацагдаж, үйл ажиллагаагаа амжилттай явуулж эхэллээ.

**6.** Банкны үйлчилгээг харилцагчийн гар утсанд авчирсан цогц шийдэл буюу гар утастай хүн бүр ашиглах Мост мони үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүллээ.

**7.** Үндэсний ₮ картыг зах зээлд анхлан нэвтрүүлэгч эрхийг Монголбанкнаас ХХБ-ийг сонгон олгосон юм.

**8.** Дэлхийд борлуулалтаараа 2-рт бичигдэж буй UnionPay төлбөрийн картыг төгрөг, доллар, юанийн 3-н данстайгаар нэг картад багтаан шийдсэн нь харилцагчдын талархлыг хүлээж, өндөр борлуулалттай олон улсын карт болон зах зээлд байр сууриа эзлэж байна.

**9.** Монгол улсын Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн биржтэй урт хугацааны стратегийн түншлэлийн дагуу хөрөнгийн биржийн цогц "Миллениум Ай Ти" системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан, үнэт цаасны төлбөр тооцооны клирингийн үйлчилгээг ХХБанк анхлан эхлүүллээ.

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА




## НИЙГЭМДЭЭ САНАА ТАВЬДАГ,
ХАРИУЦЛАГАТАЙ БАЙХ НЬ БИДНИЙ ҮҮРЭГ

### Байгаль орчин, нийгмийн хариуцлагын олон улсын стандартыг Монголд нэвтрүүллээ.

Нидерландын хөгжлийн банк (НХБ)-наас ХХБ-тай хамтран "Хүрээлэн буй орчин, нийгмийн хариуцлага"-ын бодлого хэрэгжүүлэн, Монгол улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд томоохон шинэчлэл хийлээ. Энэ ажлын хүрээнд ХХБ зээл олгохдоо уламжлалт стандарт болох зээлийн эргэн төлөлт, тухайн зах зээл, валютын ханшийн гэх мэт эрсдэлүүдээс гадна байгаль орчиндоо ээлтэй, нийгэмдээ ач тустай, улсынхаа ирээдүйд үр өгөөжөө өгөх бизнесийг дэмжин зээл олгодог болсон юм.

### Монголын эдийн засгийн хөгжлийг хурдасгахад бид байнгын, тасралтгүй хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг.

Олон улсын хэмжээний Mining Mongolia, Discover Mongolia, Coal Mongolia, IPO Mongolia, Future Mongolia, Монголын Эдийн Засгийн Чуулган зэрэг чуулга уулзалтуудад өндөр ач холбогдол өгөн, эдийн засгийн орчинг сайжруулах, хөгжлийг хурдасгахад хувь нэмрээ оруулан, дэмжин ажиллалаа. Дээрх чуулгануудаар Монголын эдийн засагт тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх гарцыг хэлэлцдэг юм.

### Санхүүжилт шаардлагатай нийгмийн аль ч хэсэгт бид хүрэхийг зорьдог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 29-р дунд сургуультай 8 дахь жилдээ хамтран ажиллаж, жирийн хүүхдүүдтэй мөр зэрэгцэн алхаж чаддаггүй бяцхан үрсийг баярлуулан, хандив дэмжлэг үзүүлдэг. Мөн Макс групптэй хамтран нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд санхүүгийн хувьд ирээдүйдээ итгэлтэй байх, мөнгөн хуримтлалын ач тусыг ойлгуулах зорилгоор Хүүхдийн баярын бэлэг болгон, Хадгаламжийн дэвтэр өргөн барилаа.

Монгол дахь Францын Нотредамийн нэрэмжит асрамжийн газрын 10 жилийн ойг тохиолдуулан, автомашин худалдан авахад зориулж санхүүгийн туслалцаа, дэмжлэг үзүүллээ.

### Урлагийн гайхамшиг биднийг хөглөдөг.

Монголын рок попын хөгжилд өөр өөрийн үнэ цэнэ, өнгө төрхийг бий болгосон, олонд нэртэй Хурд, Номин талст хамтлагуудын ойн баярын тоглолтонд дэмжлэг үзүүлэн, үзэгч олонд тоглолтоо сонирхуулахад нь дэм өгөн, хамтран ажиллав.

Гайхамшигт сонгодог урлагийг байнга дэмжин хөгжүүлэхийг зорьж, жил бүр энэ салбарт хөрөнгө зарцуулдаг бидний хувьд 2012 онд Хөгжим бүжгийн коллежийн авьяаслаг сурагчдын олон улсад авьяасаа сорих тэмцээн уралдааны зардал, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Жааз хөгжмийн тоглолтуудыг ивээн тэтгэж, санхүүжүүллээ.

# ДЭЛХИЙД ҮНЭЛЭГДСЭН ШАГНАЛУУД
















**ДЭЛХИЙ ДАХИНД МОНГОЛ УЛСЫН ХХБАНК ОНЦГОЙРОН ҮНЭЛЭГДЭЖ,**
ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ШАГНАЛ УРАМШУУЛЛЫГ БАЙНГА ХҮРТДЭГ

## МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК

Ази тивд санхүү, эдийн засгийн мэдээ мэдээлэл, чиг хандлагыг бодитоор хүргэдэг, тэргүүлэх сэтгүүл "Finance Asia" ХХБ-ийг "Монгол улсын шилдэг банк"-аар шалгарууллаа.

## ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ШИЛДЭГ БАНК

Дэлхийн худалдааны санхүүжилтийн "Global trade review" (GTR) сэтгүүл Монгол улсад худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр мэргэшсэн, өндөр түвшинд, хамгийн найдвартай үйлчилгээг үзүүлдэг банкийг санал асуулгаар тодруулсан ба уг асуулгад ХХБанк илт давуу 1-рт жагсаж, "Худалдааны санхүүжилтийн шилдэг банк"-аар 2 дахь удаагаа шагнагдсан юм.

## МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГЫН БАНК

Их Британийн "Global banking & finance review" олон улсын байгууллагаас дэлхийн шилдэг банк санхүүгийн байгууллагуудын дунд зохион байгуулдаг шалгаруулалтаас ХХБанк 2012 оны "Монгол улсын шилдэг байгууллагын банк" шагналыг олголоо.

## ТӨСЛИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТООР ТЭРГҮҮЛЭГЧ БАНК

JICA олон улсын байгууллага "ЖДҮ-ийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах" 2 үе шаттай зээлийн төсөлд Монголын 7 арилжааны банк хамтран ажилласнаас, төслийн 2 дахь шатны эх үүсвэрээс ХХБанк 16 тэрбум төгрөгийн төслийн зээлийг олгож, зээлийн ашиглалтаараа тэргүүлэн, шагнал гардлаа.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ




## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**ТУЗ-ийн дарга**
Должин ЭРДЭНЭБИЛЭГ

**Гишүүд**
Зуунай ШАГДАРСҮРЭН
Рандолф КОППА
Тамир ЦОЛМОН
Чулуунбаатар ЭНХБОЛД

**Банкны нарийн бичгийн дарга**
Дашзэгвэ ДАВААЖАВ

## УДИРДЛАГЫН БАГ

**Ерөнхийлөгч**
Рандолф КОППА

**Гүйцэтгэх захирал**
Балбар МЭДРЭЭ

**Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч**
Онон ОРХОН

**Ерөнхий аудитор**
Паламдорж ГАНТУУЛ

**Гүйцэтгэх захирлын орлогч**
Санжаасүрэн ОРГОДОЛ

**Гүйцэтгэх захирлын орлогч**
Дэмчигжав ОТГОНБИЛЭГ

**Гүйцэтгэх захирлын орлогч**
Лхагвасүрэн СОРОНЗОНБОЛД

**Гүйцэтгэх захирлын орлогч**
Дамбийжав ХҮРЭЛБААТАР

# УДИРДЛАГЫН БАГ



**Ноён О.ОРХОН**
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч



**Хатагтай П.ГАНТУУЛ**
Ерөнхий аудитор



**Ноён Д.ХҮРЭЛБААТАР**
Гүйцэтгэх захирлын орлогч



**Хатагтай Д.ОТГОНБИЛЭГ**
Гүйцэтгэх захирлын орлогч



**Ноён С.ОРГОДОЛ**
Гүйцэтгэх захирлын орлогч



**Ноён Л.СОРОНЗОНБОЛД**
Гүйцэтгэх захирлын орлогч




# БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ БИЗНЕС




"Монгол улсын шилдэг байгууллагын банк 2012" – Их Британийн "Global banking and finance review" байгууллага Монгол улсаас Худалдаа, хөгжлийн банкинд олголоо.

# БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ БИЗНЕС








Дотоодын эдийн засгийн хөгжлийг тодорхойлж байдаг компани, корпорациуд ХХБ-тай олон жилийн үр ашигтай хамтын ажиллагаатай байсаар ирсэн нь байгууллагын бизнест тасралтгүй 22 жил тэргүүлж ирсний тод илрэл юм.

Монгол улсын байгууллагын зах зээлийн 30 орчим хувийг дангаараа эзэлж, томоохон байгууллагуудын санхүүгийн хэрэгцээг хангахуйц өндөр дүнтэй зээл, бүтээн байгуулалтыг дэмжих тулгуур үзэл, харилцах, хадгаламжийн уян хатан бодлого, санхүүгийн зөвлөгөө, олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авахад дэмжлэг үзүүлэх зэргээр тэдний хүсэл шаардлагад нийцүүлсэн үйлчилгээг цогцоор нь хүргэж чаддаг юм.

## Зээлийн багцын төвлөрлийн эрсдлийг буурууллаа

2012 онд байгууллагын банкны бизнест олгосон зээл анх удаа Их наяд төгрөгт хүрсэн нь түүхэнд байгаагүй өндөр өсөлт бөгөөд өнгөрсөн жилийн эцэстэй харьцуулахад 138.1 хувиар өсч 1 их наяд 820 сая төгрөгт хүрлээ.

Сүүлийн жилүүдэд манай улсын уул уурхайн салбарын бүтээн байгуулалттай холбоотойгоор бид энэ салбарыг дэмжиж, санхүүжилтээ идэвхитэй нэмэгдүүлсэний үр дүнд нийт зээлийн багцад эзлэх уул уурхайн салбарын зээл өндөр хувь эзлэх болсон билээ. Харин 2012 онд зээлийн багцын эрсдэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг үнэлсэнээр банкны зээлийн төвлөрлийн болон чанарын эрсдэлийг бууруулах, эрсдэл багатай салбарын зээлийн багцын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилго тавьсан юм.

Энэ дагуу уул уурхайн салбарын зээлийг бууруулж, худалдааны салбарын зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажилласан нь үр дүнгээ өгсөн нь дараах үзүүлэлтээс харагдаж байна.

| № | Салбар | Тэрбум төгрөгөөр |
|---|---|---|
| 1 | Худалдаа | 326.12 |
| 2 | Уул уурхай | 275.57 |
| 3 | Үйлдвэр | 180.54 |
| 4 | Барилга | 167.36 |
| 5 | Үйлчилгээ | 30.62 |
| 6 | Тээвэр, холбоо | 30.59 |
| 7 | Хөдөө аж ахуй | 23.10 |
| 8 | Үл хөдлөх хөрөнгө | 21.07 |
| 9 | Банк санхүү | 11.83 |
| 10 | Иргэд | 6.71 |
| 11 | Эрүүл мэнд | 5.44 |
| 12 | Бусад | 3.35 |
| | **Нийт** | **1,082.30** |

## Зээлийн багцын чанар





Монгол улсын Засгийн газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлсэн "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS", "Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд 52,7 тэрбум төгрөгийн зээлийг үндэсний компаниудад олгож, Засгийн газрын үнэ тогтворжуулах бодлогыг дэмжин ажилласан юм.

## Төслийн зээлийг идэвхитэй олгож, 79 тэрбум төгрөгийн зээлийн багцтай боллоо.

Монгол улсад Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны банк, Германы KfW зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслийн зээлүүдийг санхүүжилт шаардлагатай салбаруудад идэвхитэй олгож, төслийн зээлийн багцыг 31,2 тэрбум төгрөгөөс 79,4 тэрбум төгрөгт хүргэсэн нь мөн л өндөр өсөлт, онцгой амжилт байлаа.

Амжилттай санхүүжүүлсэн төслүүдийг дурдвал:

- Засгийн газрын ЖДҮ-ийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээлийн төслийн хүрээнд 540.0 сая төгрөгийн төсөл
- Ноос ноолуурын салбарыг дэмжих төслийн хүрээнд 26,447.0 сая төгрөгийн төсөл
- ЯОУХАБ-ын зээлийн төслийн хүрээнд 5,407.3 сая төгрөгийн төсөл
- KFW банкны төслийн хүрээнд 600.0 мянган еврогийн төсөл
- АХБ-ны Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төслийн хүрээнд 800.0 сая төгрөгийн төсөл

## Монгол улсын худалдааны санхүүжилтийн үйлчилгээний 50 хувийг дангаараа гүйцэтгэдэг.

Банк байгуулагдсан цагаас эхлэн өнөөдрийг хүртэл хамгийн найдвартай, мэргэшсэн худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж ирсэн ХХБанк зөвхөн өнгөрсөн онд л гэхэд гадаад худалдааны санхүүжилтийн 500 орчим аккредитив, баталгааны үйлчилгээг үзүүллээ. Монголбанкны судалгаагаар, 2012 оны байдлаар нийт худалдааны санхүүжилтийн үйлчилгээний 50 хувийг ХХБанк дангаараа гүйцэтгэж байна.

Монгол улсын гадаад худалдааг хөгжүүлэх, өндөр түвшинд хүргэх зорилгоор тогтмол хийгддэг үйл ажиллагаануудын нэг нь "Гадаад худалдааны санхүүжилт" зөвлөгөөн юм. Уг зөвлөгөөнийг Монголбанктай хамтран зохион байгуулж, гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээг улам сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжүүдэд бодитой мэдээлэл, зөвлөгөөг хүргэх, мөн цаашдын хөгжлийн талаар хэлэлцлээ. 2013 оноос эхлэн "Гадаад худалдааны санхүүжилт" зөвлөгөөнийг ХХБанк бие даан дангаараа зохион байгуулж, худалдааны санхүүжилтийн арга хэрэгслүүдийн давуу тал, боломжуудыг бизнесийн байгууллагуудад таниулах юм.



# ИРГЭДИЙН БАНКНЫ БИЗНЕС

MoneyGram мөнгөн гуйвуулга VISA MasterCard MostMoney төлбөрийн нэгдсэн үйлчилгээ UnionPay 银联 JCB

# ИРГЭДИЙН БАНКНЫ БИЗНЕС













Байгууллагын банкны бизнест нэгэнт хүчирхэг байр сууриа тогтоосон ХХБанк иргэдийн зах зээлд үйл ажиллагаагаа өргөжүүлэх бодлого баримтлаж, иргэдийн өдөр тутам шаардлагатай дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг эрчимтэй нэвтрүүлж, иргэдийн зээлээ нэмэгдүүлж, салбарын хүрээгээ тэлж байна.

2012 он банкны салбарын өрсөлдөөн ихээхэн өрнөсөн жил байж, арилжааны банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгөө хүүгийн өрсөлдөөнөөр нэмэгдүүлэх бодлого баримталсан бол ХХБ-ны хувьд хадгаламжийн хүүг хэвийн төвшинд барих, хэт өндөр хүүгийн хөөсрөлтөд оролцохгүй байх зарчмаар ажиллалаа.

**Орчин үеийн тохилог орон сууцтай болох иргэдийн зорилгыг санхүүжилтээр дэмжих нь ХХБ-ны бодлого юм.**

Өнгөрсөн онд ХХБ-наас иргэдэд олгосон нийт зээлийн 50 хувийг дангаараа орон сууцны зээл эзлэж байгаа нь Монгол улсын иргэдээ орон сууцжуулах, амьдралын түвшинг нь ахиулах бодлогын чанартай үйл ажиллагаа юм.

Орон сууцны зээлийг ХХБ-наас иргэд сонгох хүсэлтэй байдаг нь зах зээл дээр хүүгийн хамгийн бага түвшин, урт хугацаа, бусдаас бага урьдчилгаа бүхий нөхцлийг бий болгож, бүх салбараараа байнгын, тасралтгүй олгох үйл ажиллагаа жигдэрсэнтэй холбоотой юм.

| | |
|---|---|
| 50.0% | ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ |
| 22.0% | ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ |
| 14.0% | БИЗНЕСИЙН ЗЭЭЛ |
| 6.0% | УХЭХ-ИЙН ЗЭЭЛ |
| 4.0% | ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ |
| 4.0% | БУСАД ЗЭЭЛ |



2012 онд иргэдэд зориулсан зээлийн үйлчилгээг шинээр нэмэгдүүлсэн нь Аяллын зээлийн үйлчилгээ юм. "Женко тур бюро" компанитай хамтран хэрэгжүүлж буй энэхүү Аяллын зээл нь тус компаниар үйлчлүүлэн, дэлхийн улс орнуудаар аялах, амрах хүсэлтэй хэн бүхэнд зориулагдлаа.

Мөн богино хугацааны яаралтай санхүүгийн хэрэгцээ гарсан үед картын данснаасаа хүссэн үедээ зээл авах эрхийн үйлчилгээг зөвхөн картын дансаар хязгаарлахгүйгээр иргэдийн бүх төрлийн харилцах дансанд олгох болсон юм.

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хүүхдийн мөнгө олгох үйл ажиллагааг дэмжин оролцож, хүүхдийн нэрийн дансыг бүх салбар, тооцооны төвөөр нээж байгаа ба 2012 оны эцсийн байдлаар хүүхдийн нэрийн 10,000 данс ХХБ-нд нээгдэж, түүнээс 60 гаруй хувь нь тогтмол шилжүүлгээр дамжин хүүхдийн хадгаламж руу шилжиж байгаа нь иргэдийн хуримтлал бий болгох соёл дээшилж, хүүхдээ нэр хүндтэй, тогтвортой банкны хадгаламж эзэмшигч болгохыг чухалчилдаг нь харагдаж байгаа юм.

**Банкны үйлчилгээг гар утсаараа авах шилдэг шийдэл Мост Мони үйлчилгээг нэвтрүүллээ.**

Олон улсын банкуудын нэвтрүүлж буй гар утсаараа төлбөр тооцоо гүйцэтгэх шилдэг шийдлийг ХХБанк Монголд анх удаа цогцоор нь нэвтрүүлж, мөнгөн шилжүүлэг, тэр дундаа банк хоорондын шилжүүлэг, олон төрлийн худалдан авалт, орон сууц, цахилгаан зэрэг билл төлбөрүүд, бэлэн орлого зарлагын гүйлгээг ч Мост Мони үйлчилгээг ашиглан гүйцэтгэх боломж 2012 онд нээгдсэн юм.

2012 оны 9-р сард зах зээлд нэвтрүүлсэн Мост Мони үйлчилгээ оны эцсийн байдлаар 15,700 хэрэглэгчтэй болж, үүрэн телефоны Мобиком корпорацийн хэрэглэгчид ашиглаж байгаа ба 2013 онд бусад операторуудыг уг үйлчилгээнд холбохоор техникийн тохиргоо, өргөтгөлийн ажлууд хийгдэж байна.











### Иргэдэд зориулсан хамгийн хямд, шуурхай гуйвуулгын үйлчилгээнүүд шинэ шатанд гарсаар байна.

Олон улсын мөнгөн гуйвуулгын MoneyGram үйлчилгээг ХХБ Монголчууддаа анх удаа хүргэж, хамгийн хямд үнээр, 10-хан минутад дэлхийн хаана ч мөнгө шилжүүлэх давуу талтай уг үйлчилгээг байнга сайжруулах боломжуудыг эрэлхийлдэг юм.

Өнгөрсөн онд шимтгэлийн нөхцөлд судалгаа дүгнэлт хийж, MoneyGram байгууллагатай зөвшилцсөний дүнд шимтгэлийн шатлалд өөрчлөлт оруулж, иргэдэд илүү таатай нөхцлийг бий болголоо.

БНСУ-аас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгыг бага зардлаар, хурдан гүйцэтгэх боломжтой PayEasy мөнгөн гуйвуулгын үйлчилгээ дахин нэг шатаар ахиж, Солонгосын Hana банкинд ностро данс нээснээр төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, зөвхөн иргэдээс гадна аж ахуйн нэгж, байгууллагуудын ам.долларын болон воны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг илүү өргөн хүрээтэйгээр үзүүлэх боломжтой болсон юм.

### Төлбөрийн картын бизнес цар хүрээгээ тэлж, 3-н валютыг нэг дор багтаасан олон улсын ЮнионПэй картыг нэвтрүүллээ.

Бид өөрсдөө карт гаргах, төлбөрт хүлээн авахын зэрэгцээ арилжааны бусад банкуудын картын төлбөр тооцоог дэмжин, тэдгээрийн карт эзэмшигчдийн хэрэглээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор свич, процессингийн үйл ажиллагааг эрхэлж, 2012 онд шинээр ХасБанк, Төрийн банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банкууд гишүүнээр нэмэгдэж, нийт 8 гишүүн банктай боллоо. Түүнчлэн JCB картыг Монгол улс даяар хүлээн авах өргөн боломж өнгөрсөн онд бүрдсэн юм.

Картын бизнесийн салбарт өнгөрсөн онд хийсэн томоохон онцлох үйл явдал нь Олон улсын UnionPay байгууллагатай хамтран төгрөг, юань, долларын гурван валютын дансыг нэг картад багтаасан олон улсын ЮнионПэй картыг нэвтрүүлсэн нь зах зээлд амжилттай нэвтэрсэн юм. ЮнионПэй картыг БНХАУ руу тогтмол зорчдог, бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, оюутнууд ашиглахын зэрэгцээ дотооддоо цалингийн карт болгон ашиглаж, үйлчилгээний байгууллагуудаар төлбөр тооцоогоо гүйцэтгэдэг боллоо.

Монгол улсад бэлэн бус төлбөр тооцоог байнгын хэрэглээ болгохыг эрмэлздэг бидний хувьд картаар үйлчлэгч байгууллагуудын тоог нэмэгдүүлэн 2000 орчимд хүргэсэн бол бэлэн мөнгөний АТМ 149-д хүрээд байна.

### Уртасгасан цагаар ажилладаг Дөчин мянгат салбарыг шинээр нээв.

Өнгөрсөн онд шинээр Хан-Уул, Нархан, Дөчин мянгат гэсэн 3 салбарыг шинээр байгуулж, ХХБанк нийт 45 салбар, тооцооны төвтэй болж байгаа юм.

Дөчин мянгат салбар нь ажлын өдрүүдэд өглөө 08.00 цагаас үдшийн 23.00 цаг хүртэл уртасгасан цагаар ажилладаг нь харилцагчдын талархлыг хүлээж байгаа ба цаашид дүүрэг бүрт уртасгасан цагийн хуваарьтай салбар байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.





# ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ГАДААД ХАРИЛЦАА




ОУ-ын Худалдааны санхүүжилтийн GTR сэтгүүлээс 2 дахь жилдээ “Худалдааны санхүүжилтийн шилдэг банк” шагналын эзэн боллоо.



ХХБанк гадаад харилцааны арвин их туршлагатай, гадаад харилцаан дээр суурилсан банкны бүтээгдэхүүн үйлчилгээнүүд өрсөлдөгчдөөс хол давуу хөгжсөн нь 1990 онд Улсын банкны Гадаад төлбөр тооцооны газраас салбарлан байгуулагдсантай шууд холбоотой бөгөөд анхны суурь уламжлалыг орчин үетэй нийцүүлэн сайтар хөгжүүлсэн нь бидний онцлог давуу тал юм.

Монгол улсын гадаад төлбөр тооцооны 50 хувийг дангаараа гүйцэтгэдэг, олон улсын томоохон санхүүгийн байгууллагуудын хамтарсан санхүүжилтийн үйл ажиллагаанд идэвхийлэн оролцдог, дэлхийн 150 гаруй банкинд бүх голлох төрлийн валютаар харилцагчдын төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх ностро дансуудтай.

### Бондын хөрөнгө эдийн засагт өгөөжөө өгөх зорилтот бүлэгт шаардлагатай санхүүжилт болон зарцуулагдаж байна.

Олон улсад танигдсан нэр хүнддээ тулгуурлан 2007 онд 75 сая ам.доллар, 2010 онд 175 сая ам.доллар, 2012 онд 300 сая ам.долларын бонд олон улсын хөрөнгийн захад арилжаалж, арилжаа бүрт захиалгын санал төлөвлөсөн хэмжээнээс 3-4 дахин их ирж байсан нь ХХБ-ны гадаад дахь нэр хүндийг улам өсгөсөн явдал болсон юм.

Өнгөрсөн онд гаргасан 300 сая ам.долларын 8.5 хувийн хүүтэй барьцаагүй бонд нь Европын дунд хугацааны бондын хөтөлбөрийн лимитийг 700 сая ам.доллар болгон нэмэгдүүлсэн билээ.

SINGAPORE EXCHANGE ING Bank of America Merrill Lynch

**Хөрөнгө оруулагчид**

| | |
|---|---|
| 60.0% | ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА |
| 25.0% | ХУВИЙН БАНКУУД |
| 15.0% | БАНКУУД БОЛОН БУСАД |





**Газар зүйн байрлалаар**

| | |
|---|---|
| 60.0% | АЗИ |
| 35.0% | ЕВРОП |
| 5.0% | ОФШОР, АНУ |

Бондоос орж ирсэн хөрөнгө ХХБ-ны харилцагчид тухайлбал, барилга, худалдаа, жижиг дунд үйлдвэрлэл, ноос ноолуур, уул уурхайн салбарын зээлдэгчид, иргэдийн орон сууцны зээл зэрэг эдийн засагт үр өгөөжөө өгөх зорилтот бүлэгт шаардлагатай санхүүжилт болон зарцуулагдаж байна.

### Гадаад худалдааны санхүүжилтийн зээлийг Монголдоо хамгийн идэвхитэй олгодог.

ХХБ-ны өргөн гадаад харилцааны нэг хэсэг нь худалдааны санхүүжилт, аккредитив нээх, харилцагчийн аккредитивийг гадаадын гуравдагч банкаар баталгаажуулах, экспорт кредитийн агентлагуудын даатгалтай худалдааны санхүүжүүлтийн зээлийг харилцагчиддаа дамжуулан олгох явдал юм.

2012 оны эцсийн байдлаар гадаадын нэр хүнд бүхий 34 банкнаас ХХБ-ны харилцагчдын гадаад худалдааны санхүүжилтэд зориулж, 269 сая ам.долларын худалдааны санхүүжилтийн зээлийн шугам баталж өгсөн байна.




Энэ нь гадаадын банкууд манай харилцагчдын нээсэн гадаад худалдааны аккредитив, баталгааг ХХБ-наас ямар нэгэн барьцаа баталгаа шаардахгүйгээр баталгаажуулж байгаа хэрэг төдийгүй гадаад дахь нэр хүндийг давхар харуулж байгаа юм.




# ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК

## Бидний гүйцэтгэсэн томоохон төслүүд

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Goldman Sachs

4.8 ХУВЬ
ХУВЬЦААНЫ САНХҮҮЖИЛТ

Монголын санхүүгийн зах зээлийн түүхэн үйл явдал болох олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банк Голдман Сакс Монголын аж ахуйн нэгжид хийсэн анхны хөрөнгө оруулалтанд ерөнхий зохион байгуулагчаар оролцов.

Ерөнхий зохион байгуулагч

TDB CAPITAL

---

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ЕВРОПЫН ДУНД ХУГАЦААНЫ
$700 сая долларын
хөтөлбөрийн хүрээнд
$300 САЯ ДОЛЛАРЫН БОНД

Монгол улсаас анх удаа олон улсад хоёр удаа дараалан амжилттай бонд гаргасан Худалдаа, хөгжлийн банк гурав дахь удаагаа $300 сая долларын бондоо амжилттай арилжааллаа.

Зохион байгуулагчид

Bank of America Merrill Lynch    ING

Хамтран зохион байгуулагч

TDB CAPITAL

---

Глобал дунд хугацааны $5 тэрбум долларын хөтөлбөрийн хүрээнд
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
$1.5 ТЭРБУМ ДОЛЛАРЫН БОНД

ACHIEVEMENT AWARDS FinanceAsia 2012

"Шилдэг засгийн газрын өрийн бичиг",
"Шилдэг Монгол улсын хэлцэл"

ASIAMONEY

"Шилдэг засгийн газрын өрийн бичиг"

Хамтарсан Тэргүүлэх Менежерүүд

Bank of America Merrill Lynch    Deutsche Bank    HSBC

J.P.Morgan    TDB CAPITAL

# ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК



Хамгийн чанартай үйлчилгээг харилцагчиддаа хүргэх эрхэм зорилготой Ти Ди Би Капитал ХХК нь үйлчлүүлэгчдийнхээ бизнесийн өсөлт болон санхүүгийн зах зээлд оролцох идэвхийг нэмэгдүүлэх зорилготойгоор ажилладаг. Бид корпорацийн санхүүжилт, үнэт цаасны зуучлал, мэргэжлийн мэдээлэл судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг олон улсын жишигт нийцсэн хөрөнгө оруулалтын банкны цогц үйлчилгээг харилцагчиддаа хүргэхийг зорин ажиллаж байна.

"Ти Ди Би Капитал" ХХК нь байгуулагдсан цагаасаа эхлэн харилцагчдынхаа онцлог, санхүүгийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахуйц хөрөнгө оруулалтын төгс шийдэл, санхүүжилтийн олон хэлбэрүүдийг санал болгон, томоохон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай зохион байгуулж байна. 2011-2012 онд бид харилцагчиддаа 160 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг дотоодын зах зээлээс бие даан амжилттай татан төвлөрүүлж өгсөн бөгөөд олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран 1.8 тэрбум ам.долларын санхүүжилтийг олон улсын зах зээл дээр амжилттайгаар хамтран зохион байгуулсан нь энэхүү үйлчилгээгээр зах зээлд тэргүүлэгч болгож чадлаа.

Бидний давуу тал

- Хөрөнгө оруулалтын банкны цогц бүтээгдэхүүн үйлчилгээ
- Мэргэжлийн өндөр түвшний, чадварлаг туршлагатай хамт олон
- Олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран болон бие даан томоохон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай зохион байгуулсан
- Дотоодын болон олон улсын зах зээлд нэр хүндтэй
- Харилцагчийн хүчирхэг бааз суурьтай, олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банк, сангууд болон хөрөнгө оруулагчидтай тогтоосон харилцаа

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

### Корпорацийн санхүүжилт

Олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын банк, сангуудтай хамтран ажилласан туршлага дээрээ үндэслэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлж, үндэсний компаниудын хувьцаа, бонд гаргах, зээлийн санхүүжилт татах зэрэг ажлыг зохион байгуулж байна. Мөн зайлшгүй шаардлагатай IPO гаргах бэлтгэл үеийн санхүүжилт, уул уурхайн хайгуулын ажлын болон экспортын урьдчилгаанд зориулагдсан хөрөнгийн эх үүсвэрийг татан дотоодын стратегийн томоохон төслүүдийг санхүүжүүлэхийг зорьж байна.

Хөрөнгө оруулалт

- Хувьцааг нээлттэй зах зээлд анх удаа санал болгох / IPO/
- Нэмэлт хувьцаа гаргах
- Хаалттай хөрөнгө оруулалтууд
- Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах

Зээл, өрийн бичгийн санхүүжилт

- Засгийн газрын бонд
- Компанийн бонд
- Хамтын санхүүжилтийн зээл, зээлийн шугамууд
- Хоёрдогч өглөг
- Бусад өр, зээлийн хэрэгслүүд

### Үнэт цаасны зуучлал

Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлт болон уул уурхайн хөгжил нь олон улсын хөрөнгө оруулагчдын Монгол улсын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлж байна. Бид энэхүү боломжийг хөрөнгө оруулагчдад нээхийн зэрэгцээ Монголын хөрөнгийн биржийн арилжаанд дотоодын хөрөнгө оруулагчид болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдлэгийг сайжруулах зорилгоор үнэт цаасны зуучлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцлүүлэн хүргэж байна.

- Үнэт цаасны зуучлал
- Үнэт цаасны төлбөр тооцоо

### Судалгаа шинжилгээ

Бид хөрөнгө оруулагчид болон харилцагчиддаа эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлагын талаар мэргэжлийн түвшинд бэлтгэсэн судалгаа, шинжилгээг бэлтгэн цаг алдалгүй хүргэхийг зорин ажиллаж байна. Түүнчлэн Монголын хөрөнгийн бирж болон олон улсын хөрөнгийн биржүүдэд бүртгэгдсэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудын судалгааг харилцагчиддаа хүргэж байна.

- Макро эдийн засгийн судалгаа
- Салбарын судалгаа
- Монголын болон Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны судалгаа
- Долоо хоног бүрийн хөрөнгийн зах зээлийн тойм
- Өдөр тутмын үнэт цаасны арилжааны мэдээ

### Хөрөнгийн удирдлага

Бид байгууллага болон өндөр орлого бүхий иргэдэд санхүүгийн зорилтот түвшин, амжилтанд хүрэхэд нь хувьцаа, тогтмол орлого бүхий үнэт цаас, хөрвөх чадвар бүхий үнэт цаасны чиглэлээр хөрөнгийн удирдлагын үйлчилгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна.

- Дотоодын аж ахуйн нэгж, байгууллагууд
- Орлого өндөр иргэд



# ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

# ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА



ХХБанк Монгол улсын банк санхүүгийн салбарт хамгийн олон гадаад валютаар төлбөр тооцоо, гадаад гуйвуулгын үйлчилгээ үзүүлж, гадаад валют, биет алт болон мөнгөний дотоодын зах зээл дээр тэргүүлэгч байр суурийг эзэлдэг билээ.

**Валютын арилжааны нийт эргэлт 31.2 хувийн өсөлт үзүүллээ**

Монгол улсын эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг бол валютын ханш. Валютын ханш чангарах сулрах нь эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг үзүүлдэг.

Дотоодын валютын зах зээлд голлох байр сууриийг эзэлдэг ХХБ-ны хувьд валют арилжааны нийт эргэлт өмнөх оноос 31.2%-ийн өсөлттэй гарсан нь эдийн засаг, гадаад худалдааны өсөлтөөс гадна харилцагчдын тоо нэмэгдсэн, ханшийн уян хатан бодлого баримталсантай холбоотой байлаа.




**Биет алтны арилжааны зах зээлд байр сууриа бататгасаар байна**

Дотоодын арилжааны банкуудаас анх удаа 2000 онд биет алт худалдан авах албан ёсны зөвшөөрлийг ХХБанк авснаас хойш биет алтны арилжааны зах зээл дээр тасралтгүй тэргүүлэх байр суурийг эзэлсээр байна.

2012 онд ХХБанк алт олборлогч 33 аж ахуйн нэгжээс нийт 1.4 тонн алт худалдан авч, арилжаа хийсэн бөгөөд алт олборлогч зарим аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлүүд хүчингүй болгосонтой холбоотойгоор алтны тушаалт буурах хандлагатай байсан ч шинэ харилцагчдаас алт худалдан авч эхэлсэн нь зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалахад голлох нөлөөг үзүүлсэн юм.

**Алтны зах зээл**




Харилцагчдын өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй санхүүгийн хэрэгцээнд зориулж олон улсын зах зээлийн ханшийн хүчтэй хөдөлгөөнөөс өөрсдийн хөрөнгөө хамгаалахад нь зориулж мөнгөн хөрөнгийн удирдлагын цогц үйлчилгээнүүдийг сайжруулан хүргэж байна.

**Дотоодын мөнгөний зах зээлд бондын арилжаанд идэвхитэй оролцлоо**

Өнгөрсөн онд банкны илүүдэл нөөцийн хэмжээ бага байсан нь мөнгөний зах зээл дээрх үйл ажиллагааг хөрвөх чадварыг хангах чиглэлд илүү чиглүүлэх шаардлага бий болгосон. Гэвч ТБҮЦ, ЗГҮЦ-ны арилжаануудад идэвхтэй оролцсон хэвээр байж, ялангуяа дунд хугацааны Засгийн газрын бондуудад хөрөнгө оруулалт хийж байсны үр дүнд Засгийн газрын бондын багц өмнөх оноос 5 дахин өссөн байна. Монголбанкны ЗБН-ийн шаардлага болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллахын зэрэгцээ харилцагчдын бэлэн, бэлэн тус төлбөр тооцоог цаг тухайд нь саадгүй гүйцэтгэж чадсан нь нөөцийн удирдлагын үйл ажиллагаа оновчтой байсны илрэл юм.






# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ХХБанк эрсдэлийн удирдлагыг хамгийн чухалд авч үздэг нь банкны хүлээж болзошгүй эрсдэл, алдагдлаас хамгаалах замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэх явдал юм. Эрсдэлийг хэмжих, үнэлэх талаар олон улсын чиг хандлага, шинэ тутам гарч буй арга аргачлалыг банкинд нэвтрүүлэх талаар ХХБанк салбартаа манлайлсаар ирсэн билээ.

Эрсдэлийн удирдлагыг арилжааны эрсдэлийг хэмжих, хянах, удирдах арга аргачлалыг нэвтрүүлж, Монголбанкнаас арилжааны эрсдэлийг VaR аргаар үнэлэх зөвшөөрлийг арилжааны банкуудаас хамгийн анх авч, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба зээлдэгчийн эрсдэлийн үнэлэмжийн загварыг мөн Монголд анх удаа хэрэгжүүлсэн юм.

Өнгөрсөн онд Олон улсын мэргэшсэн эрсдэлийн менежерүүдийн холбооны гишүүнээр ХХБанк элсэн орсон ба эрсдэл хариуцсан газар нэгжүүд дотоод үйл ажиллагаандаа засаглалыг хөгжүүлэх, хараат бус тайлагналын тогтолцоог хөгжүүлэхээр ажиллалаа. ХХБ-ны Эрсдэлийг удирдах тогтолцоо нь дотроо Зээлийн эрсдэлийн удирдлага, Зах зээлийн эрсдэлийн удирдлага, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага гэсэн 3-н чиглэлээр өргөжин хөгжиж байна.

### Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах зэрэг зээлийн бүхий л үйл ажиллагаандаа Базел II зарчмыг мөрдөн ажилладаг нь уг эрсдлийг бууруулах томоохон дэвшил болдог юм.

2012 онд ХХБ-ны зээлийн эрсдэлийн удирдлагадаа хэрэгжүүлсэн бодлого нь зээлийн багцын түвшинг эрсдэлийн удирдлагын сайн тогтолцооны хүрээнд өсгөн нэмэгдүүлж, олгосон зээлийн эргэн хяналтад анхаарал хандуулан ажилласнаар чанаргүй зээлийн нийт багцад эзлэх хувь 1.4 хувь болж буурлаа.

Эрсдэлтэй зээлдэгчдийг даатгалд хамруулах олон улсын туршлагыг хэрэгжүүлж эхэлсэн нь өнгөрсөн оны бас нэгэн ололт байлаа.

Зээлийн шийдвэр гаргах үйл ажиллагааг хялбар болгож, бүртгэлийн давхардалгүй болгох , гар ажиллагаанаас хамаарсан алдааг бүрэн арилгах арга хэмжээг авч амжилттай хэрэгжүүллээ.

### Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Байнгын өөрчлөгдөн шинэчлэгдэж буй зах зээлийг тасралтгүй судалгаа шинжилгээ, анализ дүгнэлтийн үр дүнд учирч болох эрсдэлийг үнэлэхийн зэрэгцээ хөрвөх чадварын эрсдэл, хүүгийн эрсдэлийн удирдлагыг зэрэг хөгжүүлэх үндэс суурийг ХХБанк Монголд анх удаа бий болгосон юм.

Макро эдийн засаг, гадаад эдийн засаг, банк санхүүгийн секторын судалгааг мэргэшсэн баг гүйцэтгэж, банкны зээл, эх үүсвэрийн түвшин дэх удирдлагуудын шийдвэр гаргалтанд туслалцаа үзүүлдэг.

Монголбанк болон Базелийн хорооноос гаргасан Базел II, III шаардлагууд, олон улсын практик зөвлөмжүүд дээр үндэслэн банкны нэр хүнд, ашигт ажиллагаа мөн харилцагчийн итгэл зэрэгтэй шууд уялддаг хөрвөх чадварын эрсдэлийг удирдах арга, аргачлалыг олон улсын стандарттай нийцүүллээ. Энэ нь хөрвөх чадварын улмаас банкны ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг нарийн тогтоон, үүсч болох гэнэтийн зардлыг бууруулах, алдагдсан боломжийн өртгийг багасгах ач холбогдолтой юм.

### Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Банкны салбарт ажиллагсдын зайлшгүй мэдэж, сэргийлж байх томоохон эрсдэл нь мөнгө угаах болон терроризмын санхvvжилт, түүнтэй тэмцэх арга зам, олон улс болон дотоодын хууль эрх зүйн зохицуулалтуудын талаар бүрэн дүүрэн ойлголттой байх явдал билээ. Уг эрсдэл нь банкны ажилтнуудын санамсаргүй үйлдлээс үйл ажиллагааны томоохон эрсдэл үүсэх магадлалтай тул "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар баримтлах ХХБ-ны бодлого, журам"-ыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Учирч болзошгүй эрсдэлийг илрүүлж үнэлэх, эрсдэлийг бууруулах урьдчилсан арга хэмжээг авах эрсдэл тогтоох ажиллагааг явуулж, холбогдох эрсдэлүүдийг үнэлэн гаргаж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах боломжит арга хувилбар, зөвлөмжийг тогтмол гаргадаг боллоо.

Мөн эрсдэл тогтоолт хийгдсэн үйл ажиллагаанд эргэн хяналт хийх аргачлалыг нэвтрүүлсэн нь өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг сайжруулж, эрсдэлээс сэргийлэх боломжийг нэмэгдүүлэх давуу талтай юм.

Харилцагчийг бүрэн, зөв таньж, үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн дутуу, буруугаас үүсэх эрсдэлээс сэргийлэх зорилгоор "Харилцагчийн мэдээлэл шинэчлэх аян"-ыг бүх салбар, тооцооны төвүүдийн дунд өрнүүллээ.




# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ





Цаг хугацаатай өрсөн өөрчлөгдөж, хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологийн хөгжлийн үр өгөөжийг банкны бизнес болон дотоод үйл ажиллагаанд шингээн, харилцагчиддаа мэдээллийн технологид суурилсан дэвшилтэт олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр нэгэн зэрэг үйлчлэх боломжийг ХХБанк салбартаа анхлан бий болгосон.

Мэргэшсэн ажилтнууд, өндөр технологийн хүчийг хослуулан, дотооддоо шаардлагатай программ хангамжийг захиалгаар хийж гүйцэтгэх, шинэчлэн сайжруулах, банкны үйл ажиллагааны тасралтгүй найдвартай байдлыг хангадаг мэдээллийн технологийн хөгжилдөө ХХБанк байнга хөрөнгө оруулалт хийн, онцгойлон анхаардаг.

**Мэдээллийн технологийн үйл ажиллагаандаа олон улсын аудит хийлгэж, дэлхийн стандартад нийцэж байгааг нотоллоо.**

ХХБ-ны үйл ажиллагааны цар хүрээ жил ирэх бүр нэмэгдэж, дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээг тогтмол нэвтрүүлж байгаатай холбогдуулан Мэдээллийн технологийн газрын бүтцийг шинэчилэн өргөжүүлж, орон тоог нэмэгдүүлэн, газрын харьяа гурван хэлтсийн зохион байгуулалттайгаар 50 гаруй ажилтан ажиллаж байна.

2012 онд банкны мэдээллийн технологийн үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрсэн эсэх, ямар үйл ажиллагаанд сайжруулалт хийгдэх шаардлагатай болохыг тодорхойлох зорилгоор олон улсын аудитын "Deloitte" компаниар бүрэн аудит хийлгэлээ.

Уг аудитаар ХХБ-ны мэдээллийн технологийн үйл ажиллагаа нь олон улсын нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагааны түвшинтэй харьцуулахад дундаж түвшинд, зарим талаараа дундаас дээш түвшинд байгааг дүгнэсэн юм. Аудитын зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг улам сайжруулахаар 2013 онд төлөвлөөд байна.

Картын системийн үйл ажиллагаагаа тэлж, шинээр ХасБанк, Төрийн банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банкуудыг гишүүн банкаар элсүүлж, техник технологийн иж бүрэн үйлчилгээг хүргэн, нийт 8 дэд гишүүн банкуудад картын системийн бүрэн үйлчилгээ үзүүлж байна.

**Дэлхийн банкуудын хэрэгжүүлдэг мөнгө угаалтын эсрэг тэмцэх дүрэм журмыг хэрэгжүүлэх шинэ программ хангамжийг нэвтрүүллээ.**

Банкны охин компани болон "ТиДиБи Капитал"брокер, андеррайтерийн компанийн үндсэн бүртгэлийн систем буюу дотоод үйл ажиллагааны томоохон системийг хөгжүүлэн ашиглаж эхэллээ. "ТиДиБи Капитал" компанийн дотоод бүртгэл, харилцагч, үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн данс, захиалга, шаталсан хяналт, лимит, төлбөр тооцоо, тайлангууд, хэрэглэгчийн эрхийн зохицуулалт, харилцагчийн гадаад интерфейс зэргийг цогц утгаар нь бүрэн агуулсан динамик удирдлагын функц, модулиудтайгаар зохион бүтээсэн ба бүх мэдээллийг автоматаар хөрвүүлэн, балансын үлдэгдлийг бүрэн гүйцэд хөтлөх боломжийг бүрдүүлсэн томоохон систем юм.

Дэлхийн банк, санхүүгийн байгууллагуудын хэрэгжүүлдэг мөнгө угаалтын эсрэг тэмцэх олон улсын хууль, дүрэм журмыг сахин мөрдөх программ хангамжыг Монголд анх удаа нэвтрүүлсэн банк боллоо.

Банкны баталгааг цахим хэлбэрээр илгээх Засгийн газрын төслийг анхлан амжилттай хэрэгжүүлж, "Цахим тендерийн программ хангамж"-ыг боловсруулж, Гадаад шилжүүлгийн SWIFT 7.0 шинэ системийг нэвтрүүлсэн зэргээр мэдээллийн технологийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргасаар байна.




# ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА








## ЧИН ЗОРИЛГОО БИЕЛҮҮЛЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЛЭЛИЙГ БИД ДЭМЖДЭГ.

# ЗОРИЛГО, ЗҮТГЭЛ, АМЖИЛТ

ХХБанк байгуулагдсан цаг үеэс эхлэн хүний нөөцийн удирдлагын баримталсан томоохон бодлого бол Байгууллагын соёл хэмээх ойлголтыг бий болгох, ажилтнуудаа ойлгуулах, хэвшүүлэх явдал байсан бөгөөд энэ нь өнөөдрийн "TDB соёл" юм.

2012 онд "TDB соёл"-ыг түшиглэсэн олон төслүүдийг хэрэгжүүлэх, ажилтнуудыг идэвхитэй оролцуулах, сэдэлжүүлэх, "TDB соёл"-оо уламжлан дээдлэх зорилгын дор Эссэ бичлэгийн уралдаан, Дууны шүлгийн уралдаан, Өнөөдрийн 1 цаг маргаашийн 2 цагаас илүү үнэтэй аян, Цаг ашиглалт ба ёс зүй сэдэвт багц үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.

Байгууллагын нийгмийн хангамж сайжрахын хэрээр ажилтнууд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж, байгууллагын амжилт, ашиг орлого нэмэгддэг. ХХБанк ажилтнуудынхаа нийгмийн хангамжинд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд жилээс жилд улам бүр сайжруулан бодлого баримталдаг.

2012 онд ажилтнуудын хүсэлтээр хэрэглээний болон орон сууцны зээлийн нөхцлийг сайжруулсны зэрэгцээ ажилтанд зээл авахад аль болох хялбар, чирэгдэлгүй байлгах талаас нь зээлийн үйл ажиллагааг автоматжуулах, хялбаршуулах ажлууд хийгдлээ.

Ажилтнуудын цалин 26% - иар өсч, 820 ажилтанд 11 тэрбум төгрөгийн зээл хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон нь 2011 оноос 70 хувиар өссөн дүн юм. 119 ажилтан хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцны зээлд хамрагдан, шинээр орон сууцтай болж, гал голомтоо бадраалаа.

ХХБ-ны үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж буйтай холбоотой хүний нөөцийн хэрэгцээ нэмэгдэж, 2012 онд ХХБ-ны ажилтны тоо 1218-д хүрч, өмнөх оноос 21,3 хувиар өсжээ.







# ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ГОЛ ХАРИЛЦАГЧ БАНКУУД

| | |
|---|---|
| Asian Development Bank | ADB |
| ING Bank | ING |
| Korean Eximbank | Korea Eximbank |
| Commerzbank | COMMERZBANK |
| Sumitomo Mitsui Banking Corporation | SMBC SUMITOMO MITSUI BANKING CORPORATION |
| UniCredit Bank | UniCredit Bank |
| VTB | VTB |
| Industrial and Commercial Bank of China | ICBC |
| The Export-Import Bank of the Republic of China | The Export-Import Bank of the ROC |
| Russian Agricultural Bank | Russian Agricultural Bank |
| Agricultural Bank of China | 中国农业银行 AGRICULTURAL BANK OF CHINA |
| BNP Paribas | BNP PARIBAS |
| Standart Chartered | Standard Chartered |
| Deutshce Bank | Deutsche Bank |
| Bank of China | 中国银行 BANK OF CHINA |

# НОСТРО ДАНСТАЙ БАНКУУД

| NO. | BANK NAME | LOCATION | SWIFT | CURRENCY | ACCOUNT NO |
|---|---|---|---|---|---|
| 1 | AGRICULTURAL BANK OF CHINA | HUHHOT, CHINA | ABOCCNBJ050 | USD | 05710114040000937 |
| 2 | STANDARD CHARTERED BANK | NEW YORK, USA | SCBLUS33 | | 3582023404001 |
| 3 | CITIBANK N.A., | NEW YORK, USA | CITIUS33 | | 36202093 |
| 4 | HSBC BANK USA N.A | NEW YORK, USA | MRMDUS33 | | 000304298 |
| 5 | ZAO UNICREDIT BANK | MOSCOW, RUSSIA | IMBKRUMM | | 001201442 USD 400202 |
| 6 | KOREA EXCHANGE BANK | SEOUL, KOREA | KOEXKRSE | | 963-THR-287-01-1 |
| 7 | CHINA CONSTRUCTION BANK | Huhhot, CHINA | PCBCCNBJNME | | 15014150509220100065 |
| 8 | INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA | ERLIANHAOTE, CHINA | ICBKCNBJNMA | | 0610040629200091076 |
| 9 | OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE | IRKUTSK, RUSSIA | SABRRU66 | | 30111840718000000007 |
| 10 | BAO SHANG BANK | BAO TOU, CHINA | BTCBCNBJXXX | | 001638896800060 |
| 11 | OCBC BANK | SINGAPORE | OCBCSGSG | | 503-071441-301 |
| 12 | JSC RUSSIAN AGRICULTURAL BANK | MOSCOW, RUSSIA | RUAGRUMM | | 30111840900000000008 |
| 13 | JSC VTB BANK | MOSCOW, RUSSIA | VTBRRUMM | | 30111840855550000000 |
| 14 | HANA BANK | SEOUL, KOREA | HNBNKRSEXXX | | 06091000114631 |
| 15 | COMMERZBANK AG | FRANKFURT AM MAIN, GERMANY | COBADEFF | | 400878500800 USD |
| 16 | COMMERZBANK AG | FRANKFURT AM MAIN, GERMANY | COBADEFF | EUR | 400878500801 EUR |
| 17 | ING BELGIUM NV/SA | BRUSSELS, BELGIUM | BBRUBEBB010 | | 301-0104154-57-EUR |
| 18 | CREDIT SUISSE | ZURICH, SWITZERLAND | CRESCHZZ80A | CHF | 0835-0993850-73-000 |
| 19 | BANK OF TOKYO-MITSUBISHI UFJ LTD | TOKYO, JAPAN | BOTKJPJT | JPY | 653-0439924 |
| 20 | MIZUHO CORPORATE BANK LTD | TOKYO, JAPAN | MHCBJPJT | | 5793010 |
| 21 | SUMITOMO MITSUI BANKING CORPORATION | TOKYO, JAPAN | SM-CJPJTXXX | | 5070 |
| 22 | HSBC BANK PLC | LONDON, UNITED KINGDOM | MIDLGB22 | GBP | 00334567 |
| 23 | KOREA EXCHANGE BANK | SEOUL, KOREA | KOEXKRSE | KRW | 0963 FRW 001000043 |
| 24 | AGRICULTURAL BANK OF CHINA, NEIMENGGU BRANCH | HUHHOT, CHINA | ABOCCNBJ050 | CNY | 05710101040021997 |
| 25 | CHINA CONSTRUCTION BANK, ERLIANHAOTE SUB BRANCH | HUHHOT, CHINA | PCBCCNBJNME | | 15001658408052501192 |
| 26 | BAO SHANG BANK | BAOTOU, CHINA | BTCBCNBJXXX | | 001638896800010 |
| 27 | PUDONG DEVELOPMENT BANK OF SHANGHAI | SHANGHAI, CHINA | SPDB CNSH XXX | | 99010154100000100 |
| 28 | BANK OF CHINA (HONG KONG) LIMTED | HONG KONG, CHINA | BKCHHKHH | | 012-875-60117544 |
| 29 | INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA | ERLIANHAOTE, CHINA | ICBKCNBJNMA | | 0610040629200090972 |
| 30 | BANK OF CHINA, ERLIAN BRANCH | ERLIANHAOTE, CHINA | BKCHCNBJ89N | | 152418818188 |
| 31 | HSBC BANK AUSTRALIA LTD | SYDNEY, AUSTRALIA | HKBAAU2S | AUD | 011-795630-041 |
| 32 | AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP LIMITED | MELBOURNE, AUSTRA-LIA | ANZBAU3MXXX | | 921064AUD00001 |
| 33 | CANADIAN IMPERIAL BANK OF COMMERCE | TORONTO, CANADA | CIBCCATT | CAD | 1820613 |
| 34 | ZAO UNICREDIT BANK | MOSCOW, RUSSIA | IMBKRUMM | RUB | 001201442 RUR 400202 |
| 35 | OJSC SBERBANK, BAIKALSKY OFFICE | IRKUTSK, RUSSIA | SABRRU66 | | 30111810918000000002 |
| 36 | JSC VTB Bank | MOSCOW, RUSSIA | VTBRRUMM | | 30111810455550000203 |
| 37 | JSC RUSSIAN AGRICULTURAL BANK | MOSCOW, RUSSIA | RUAGRUMM | | 30111810800000000015 |
| 38 | HONGKONG AND SHANGHAI BANKING CORPORATION LTD | AUCKLAND, NEW ZEALAND | HSBCNZ2A | NZD | 040-013294-261 |
| 39 | HANG SENG BANK LTD | HONG KONG | HASEHKHH | HKD | 250-012796-001 |
| 40 | OCBC BANK | SINGAPORE | OCBCSGSG | SGD | 517-123360-001 |
| 41 | NORDEA BANK AB | STOCKHOLM, SWEDEN | NDEASESS | SEK | 39527705290 080502 |

# ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК
# БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

**2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

## АГУУЛГА


| | |
|---|---|
| Санхүүгийн тайлангийн талаархи удирдлагын мэдэгдэл | 37 |
| Хараат бус аудиторын дүгнэлт | 38 |
| Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан | 40 |
| Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан | 41 |
| Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 42 |
| Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 43 |
| Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга | 45 |

**Худалдаа хөгжлийн банк ХХК болон түүний охин компани**
**Группын мэдээлэл**

| | |
|---|---|
| **Албан ёсны хаяг** | Монгол Улс. Улаанбаатар хот<br>Бага тойруу - 12<br>Жуулчины гудамж - 7 |
| **Төлөөлөн Удирдах Зөвлөл** | Д.Эрдэнэбилэг (Дарга)<br>Р.Коппа<br>З.Шагдарсүрэн<br>Т.Цолмон<br>Ч.Энхболд |
| **Нарийн бичгийн дарга** | Д.Даваажав |
| **Хараат бус аудитор** | "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК<br>Монгол Улс. Улаанбаатар хот |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Худалдаа, хөгжлийн банк ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Эрдэнэбилэг, Ерөнхийлөгч Р.Коппа, Гүйцэтгэх захирал Б.Мэдрээ болон Санхүү удирдлага, хяналтын газрын захирал Д.Янжмаа, бид энд хавсаргасан нэгттэсэн санхүүгийн тайлан нь банк болон түүний охин компанийн 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.

ТУЗ-ийн дарга
Д.Эрдэнэбилэг

Ерөнхийлөгч
Р.Коппа

Гүйцэтгэх захирал
Б.Мэдрээ

Санхүү удирдлага,
хяналтын газрын захирал
Д.Янжмаа

Монгол улс.
Улаанбаатар хот

2013 оны 3 дугаар сарын 19-ний өдөр

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монголулс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 70118102
www.kpmg.com/mn

## Хараат бус аудиторын дүгнэлт

**Худалдаа хөгжлийн банк ХХК-ийн**
**Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдэд**

Бид Худалдаа хөгжлийн банк ХХК ("Банк") болон түүний охин компани (хамтдаа "Групп")-ийн 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилүүдийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлбар тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаархи банкны удирдлагын хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), түүнд нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь банкны удирдлагын үүрэг, хариуцлага юм. Алдаа, залилт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна.

### Аудиторын хариуцлага

Хийсэн аудитын ажилдаа үндэслэн нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт гаргах нь бидний хариуцлага билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Энэхүү стандарт нь биднээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи зохистой нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаарддаг.

KPMG-ийн сүлжээний бис даасан гишүүн байгууллагууд нь Швейцарь улсын хуулийн этгээд KPMG International Cooperative (“KPMG International”)-ийн гишүүн юм. KPMG-ийн гишүүн байгулллага бүр хуулийн тусдаа этгээд болно.

**Хараат бус аудиторын дүгнэлт (үргэлжлэл)**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын талаархи аудитын нотолгоог олж авахын тулд горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд багтдаг. Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд залилан буюу алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлэх эрсдлийн үнэлгээ хамаарна. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс банкны нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн банкны удирдлагын хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, хийсэн тооцооллын үндэслэл болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явцад үнэлдэг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

**Дүгнэлт**

Бидний дүгнэлтээр, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группын 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

**Бусад**

Энэхүү тайлан нь зөвхөн Банкны гишүүдэд, нэгдмэл этгээд болохын хувьд зориулагдсан бөгөөд аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд банкны гишүүдээс бусад хүмүүсийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК
KPMG AUDIT LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТ33977 5543495

KPMG Samjong Accounting Corp.

**Кэй Пи Эм Жи Аудит ХХК**
Монгол Улс, Улаанбаатар хот
2013 оны 3 дугаар сарын 19-ний өдөр

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи
**Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

(мянган төгрөгөөр)

| | *Лав-лагаа* | 2012 | 2011 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө | *4* | 444,813,254 | 474,964,634 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | *5* | 456,801,610 | 344,267,368 |
| Хараат компани дахь хөрөнгө оруулалт | *6* | 2,385,599 | 2,275,956 |
| Зээл ба урьдчилгаа (цэвэр) | *7* | 1,533,271,823 | 1,123,331,907 |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас | *8* | - | 36,966,114 |
| Хоёрдогч зээл | *9* | 7,000,000 | 7,000,000 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | *10* | 131,590,999 | 79,144,992 |
| Биет бус хөрөнгө (цэвэр) | *11* | 601,831 | 433,398 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (цэвэр) | *12* | 157,148 | 579,190 |
| Бусад хөрөнгө | *13* | 123,856,952 | 51,767,230 |
| **Хөрөнгийн дүн** | | **2,700,479,216** | **2,120,730,789** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | | | |
| **Өр төлбөр** | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | *14* | 1,402,326,763 | 1,277,295,962 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | *15* | 36,518,483 | 35,063,555 |
| Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас | *16* | 1,495,638 | 171,484,469 |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | *17* | 232,964,084 | 174,380,516 |
| Татварын өглөг | | 2,481,600 | 1,501,188 |
| Гаргасан өрийн бичиг | *18* | 600,525,865 | 207,134,041 |
| Хоёрдогч өглөг | *19* | 55,528,846 | 41,693,522 |
| Бусад өр төлбөр | *20* | 128,761,887 | 72,762,692 |
| **Өр төлбөрийн дүн** | | **2,460,603,166** | **1,981,315,945** |
| **Өөрийн хөрөнгө** | | | |
| Хувьцаат капитал | *21* | 16,525,280 | 6,610,113 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 19,272,456 | 7,392,191 |
| Халаасны хувьцаа | *22* | (2,620,626) | (6,001,872) |
| Дахин үнэлгээний нөөц | *10* | 18,555,196 | 18,702,066 |
| Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн хэрэгжээгүй олз | *5* | 25,807,646 | 3,736,050 |
| Хуримтлагдсан ашиг | | 162,336,098 | 108,976,296 |
| **Өөрийн хөрөнгийн дүн** | | **239,876,050** | **139,414,844** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | | **2,700,479,216** | **2,120,730,789** |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
**Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

**(мянган төгрөгөөр)**

| | *Лав-лагаа* | **2012** | **2011** |
|---|---|---|---|
| Хүүний орлого | *23* | 213,335,115 | 143,500,481 |
| Хүүний зардал | *24* | (137,432,198) | (95,359,061) |
| **Хүүний цэвэр орлого** | | **75,902,917** | **48,141,420** |
| Шимтгэл, хураамжийн цэвэр орлого | *25* | 16,399,523 | 12,134,233 |
| Үйл ажиллагааны бусад орлого (цэвэр) | *26* | 14,303,110 | 14,176,216 |
| **Хүүний бус цэвэр орлого** | | **30,702,633** | **26,310,449** |
| **Үйл ажиллагааны орлого** | | **106,605,550** | **74,451,869** |
| Үйл ажиллагааны зардал | *27* | (32,875,568) | (20,071,451) |
| Хараат компанийн ашгаас ноогдох хувь | *6* | (2,340,356) | 74,955 |
| Үнэ цэнийн бууралтын (алдагдал) ба нөхөлт | *28* | 6,554,436 | (3,070,865) |
| **Татварын өмнөх ашиг** | | **77,944,062** | **51,384,508** |
| Орлогын татварын зардал | *30* | (14,817,338) | (9,282,677) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | **63,126,724** | **42,101,831** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | |
| Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт | *5* | 22,071,596 | 3,736,050 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн цэвэр өөрчлөлт | *10* | (146,870) | 5,284,414 |
| | | **21,924,726** | **9,020,464** |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | **85,051,450** | **51,122,295** |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
**Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

**(мянган төгрөгөөр)**

| | *Лав-лагаа* | **Хувьцаат капитал** | **Нэмж төлөгдсөн капитал** | **Халаасны хувьцаа** | **Дахин үнэлгээний нөөц** | **Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз** | **Хуримтлагдсан ашиг** | **Дүн** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр** | | 6,610,113 | 7,392,191 | (6,001,872) | 13,418,276 | - | 66,873,841 | 88,292,549 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | - | - | - | - | - | 42,101,831 | 42,101,831 |
| Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт | *5* | - | - | - | - | 3,736,050 | - | 3,736,050 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний олз | *10* | - | - | - | 5,284,414 | - | - | 5,284,414 |
| Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц | *10* | - | - | - | (624) | - | 624 | - |
| **2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр** | | 6,610,113 | 7,392,191 | (6,001,872) | 18,702,066 | 3,736,050 | 108,976,296 | 139,414,844 |
| **2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр** | | 6,610,113 | 7,392,191 | (6,001,872) | 18,702,066 | 3,736,050 | 108,976,296 | 139,414,844 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | - | - | - | - | - | 63,126,724 | 63,126,724 |
| Борлуулахаар эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт | *5* | - | - | - | - | 22,071,596 | - | 22,071,596 |
| Худалдсан халаасны хувьцаа | *22* | - | 11,880,265 | 3,381,246 | | - | - | 15,261,511 |
| Хувьцааны нэгжийн үнийн өсөлт | *21* | 9,915,167 | - | - | - | - | (9,915,167) | - |
| Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц | *10* | - | - | - | (146,870) | - | 148,245 | 1,375 |
| **2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр** | | **16,525,280** | **19,272,456** | **(2,620,626)** | **18,555,196** | **25,807,646** | **162,336,098** | **239,876,050** |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
**Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**(мянган төгрөгөөр)**

| | *Лав-лагаа* | **2012** | **2011** |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Цэвэр ашиг** | | 63,126,724 | 42,101,831 |
| Тохируулга: | | | |
| Элэгдэл ба хорогдуулалт | *10, 11, 27* | 2,763,673 | 2,218,699 |
| Хараат компанийн ашгаас ноогдох хувь | *6* | 2,340,356 | (74,955) |
| Хүүний цэвэр орлого | *23, 24* | (75,902,917) | (48,141,420) |
| Орлогын татварын зардал | *30* | 14,817,338 | 9,282,677 |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны (олз) гарз | | 4,841 | (351) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | *27* | 28,716 | 302 |
| Үнэ цэнийн бууралтын (олз) гарз | *28* | (6,554,436) | 3,070,865 |
| Үйл ажиллагааны бусад орлого | | (542,915) | - |
| **Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны** | | 81,380 | 8,457,648 |
| Зээл ба урьдчилгааны өсөлт | *7* | (405,634,813) | (662,841,490) |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаасны (өсөлт) бууралт | *8* | 36,966,114 | (36,966,114) |
| Бусад хөрөнгийн (өсөлт) бууралт (*) | *13* | (60,851,432) | (12,562,070) |
| Харилцагчийн харилцах, хадгаламжийн өсөлт | *14* | 125,030,801 | 357,351,213 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжийн өсөлт (бууралт) | *15* | 1,454,928 | (18,521,319) |
| Бусад өр төлбөрийн өсөлт (бууралт) (*) | *20* | 41,979,569 | 45,347,779 |
| Заавал байлгах нөөцийн өсөлт (бууралт) | *4, 32* | (82,471,171) | (119,348,252) |
| Бусад санхүүгийн байгууллагаас авах авлагын | *32* | 3,613,520 | 2,949,865 |
| Хүлээн авсан хүү | | 202,169,315 | 141,516,264 |
| Төлсөн хүү | | (121,796,735) | (87,418,713) |
| Төлсөн орлогын татвар | | (13,836,926) | (9,263,463) |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | **(273,295,450)** | **(391,298,651)** |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн
**Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**(мянган төгрөгөөр)**

| | *Лав-лагаа* | **2012** | **2011** |
|---|---|---|---|
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны** | | | |
| Худалдан авсан хөрөнгө оруулалтын үнэт цаас | *5* | (87,988,975) | (85,431,472) |
| Худалдан авсан үндсэн хөрөнгө | *10* | (55,343,822) | (56,033,312) |
| Худалдан авсан биет бус хөрөнгө | *11* | (490,317) | (264,336) |
| Борлуулсан өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | *12* | 669,505 | 1,283,019 |
| Худалдсан үндсэн хөрөнгө | *10* | 422,469 | 252,000 |
| Хараат компанид оруулсан хөрөнгө | *6* | (2,450,000) | (2,000,001) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(145,181,140)** | **(142,194,103)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | *17* | 58,583,568 | 123,702,369 |
| Буцаан худалдан авах гэрээгээр борлуулсан үнэт цаасны өсөлт (бууралт) | *16* | (169,988,831) | 171,484,469 |
| Гаргасан өрийн бичиг | *18* | 391,816,583 | 32,962,459 |
| Хоёрдогч өглөгийн өсөлт | *19* | 13,794,728 | 10,441,893 |
| Худалдсан халаасны хувьцаа | *22* | 15,261,511 | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **309,467,559** | **338,591,190** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)** | | (109,009,031) | (194,901,564) |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 303,286,464 | 498,188,028 |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | *32* | **194,277,433** | **303,286,464** |

(*) Хуримтлагдсан хүүгийн авлага, хуримтлагдсан хүүгийн өглөгийн өөрчлөлтөөс бусад актив, бусад пассивын хэлбэлзэлийг илэрхийлнэ.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн тайлангийн салшгүй хэсэг болно.

## 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Худалдаа Хөгжлийн Банк ХХК (цаашид "Банк" гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд юм. Банк нь Монгол Улсын Банкны тухайн хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн No.3/149 тоот тушаалаар банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд Монголбанкнаас 2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр No.8 тоот тусгай зөвшөөрлийг шинэчилж олгосон.

Дээрх шийдвэр, банкны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон банкны дүрмийн дагуу банк нь мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо, гадаад валют худалдан авах, худалдах болон банкны бусад үйл ажиллагааг өөрийн 22 салбар, 23 тооцооны төвөөр дамжуулан эрхэлж байна.

Банк нь өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалттай Ти Ди Би Капитал ХХК-ийг 2008 оны 8 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан. Ти Ди Би Капитал ХХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд Компанийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд брокер диллер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх болсон. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Банк болон түүний охин компанийн (Хамтад нь Групп гэх)-ийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

Группын шууд хамаарах толгой компани нь Luxembourg хотод үүсгэн байгуулагдсан Globull Investment and Development SCA ("Globull") компани бөгөөд тус группын 65.83 хувийг эзэмшдэг ба Globull Investment and Development ("Globull") компанийн толгой компани нь АНУ-ийн US Global Investment компани юм. US Global Investment компани нь Сентрал Азиа Майнинг ХХК болон ноён Должингийн Эрдэнэбилэг (одоогийн группын ТУЗ-ийн дарга) эзэмшлийн консорциум бөгөөд группын 7.32 хувийг шууд эзэмшдэг. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар US Global-ийн шууд болон шууд бусаар Globull-аар дамжуулан Группд эзэмшиж буй хувь нь ойролцоогоор 73.14 байна. Групп нь 2012 онд нийт 283,877 ширхэг халаасны хувьцаанаас 157,862 ширхэгийг буюу 4.78 хувийг хувийн хөрөнгө оруулагчид худалдсан. Үүний үр дүнд 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар группын эргэлтэнд байгаа нийт энгийн хувьцааны 23.05 болон 18.27 хувь нь иргэн, хувь хүмүүсийн эзэмшилд байна.

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН СУУРЬ

### Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим

Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Монголбанкнаас батлан гаргасан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцэхгүй дараах зүйлс байгаа бөгөөд холбогдох тодруулгуудад дэлгэрэнгүй тайлбарласан болно. Үүнд:

- Зээлийн болзошгүй эрсдлийн сан, авлага, аккредитив, ашиглаагүй зээлийн үүрэг болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн хасагдуулга
- Хойшлогдсон татварын нягтлан бодох бүртгэл

Группийн удирдлагаас нэгтгэсэн санхүүгийн тайланг 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлан гаргасан.

### Үнэлгээ

Дараахаас бусад зүйлсийн хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн.

- Бодит үнэ цэнээр хэмжигдэх дерватив санхүүгийн хэрэгслүүд
- Бодит үнэ цэнээр хэмжигдэх арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Худалдан авсны дараа бодит үнэ цэнээр бүртгэх болсон үндсэн хөрөнгө

### Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргасан валют

Группын үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайланг нэгжийн оронг мянгачилсан төгрөгөөр бэлтгэсэн.

### Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнд нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг өөрчлөлт хийгдсэн тухайн жилд болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН СУУРЬ (үргэлжлэл)

**Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ (үргэлжлэл)**

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд нөлөөлөхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх Группын шүүмжлэлтэй үнэлэмж болон тооцоололын тодорхойгүй байдлын нэг хэсэг нь зээлийн эрсдлийн сан болон санхүүгийн хэрэгсэлүүдийн үнэлгээ юм.

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, өөрчлөлт**

***(i) СТОУС 7 "Санхүүгийн хэрэглүүр:Тодруулга-д хийсэн өөрчлөлт***

Групп нь 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон СТОУС 7 "Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга"-д хийсэн өөрчлөлтийг мөрдөж эхэлсэн. Энэхүү өөрчлөлтөөр бүтнээрээ данснаас хасагдаагүй шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн төрөл тус бүрээр шилжүүлсэн хөрөнгийн шинж чанар, дансны үлдэгдэл, эрсдэл болон өгөөжийн талаар тодруулахыг шаардсан.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Групп нь тайлант жилд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хэрэгжиж эхэлсэн бодлогоос бусад доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энд үзүүлсэн бүх тайлант жилүүдэд тогтвортойгоор хэрэглэсэн болно.

**Нэгтгэлийн суурь**

***(i) Охин компани***

Охин компани нь Групп компаниар удирдагдах бөгөөд охин компани бүрийн санхүүгийн тайлангууд нь охин компани дахь группын хяналт эхэлсэн өдрөөс эхлэн дуусах өдөр хүртэл нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдэнэ.

***(ii) Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт***

Хараат компаний санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод Групп мэдэгдэхүйц нөлөөтэй боловч хяналтгүй байна. Групп өөр компаний саналын эрхийн 20-50 хувийг эзэмшиж байгаа тохиолдолд мэдэгдэхүйц нөлөөтэй гэж үзнэ.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар, түүхэн өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь хараат компанийн орлого зарлын Группт ноогдох хувь болон өмчийн хөдөлгөөн зэргийн хараат компани дахь эзэмшлийн хувь эхэлсэн өдрөөс зогсох өдөр хүртэл харуулна. Группт ногдох алдагдлын хэмжээ оруулсан хөрөнгийн хувиас хэтэрсэн тохиолдолд хүүгийн дансны үлдэгдэл, урт хугацаат хөрөнгө оруулалт зэргийг тэг хүртэл бууруулж, түүнээс хойшхи алдагдлын хүлээн зөвшөөрөлтийг Группын хүлээх үүрэг хариуцлагын хүрээнд хөнгөлнө.

***(iii) Нэгтгэлийн үр дүнд хаагдах ажил гүйлгээ***

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх явцад компани хоорондын ажил гүйлгээгээр гарсан компани хоорондын дансны үлдэгдэл, ажил гүйлгээ, хүлээн зөвшөөрөгдөөгүй орлого зарлага нь устгагддаг. Хараат компанитай хийгдсэн ажил гүйлгээний үр дүнд үүссэн хүлээн зөвшөөрөгдөөгүй олз нь Группын оруулсан хөрөнгө оруулалт руу хаагдана. Харин хүлээн зөвшөөрөгдөөгүй гарз нь хүлээн зөвшөөрөгдөөгүй олзтой нэгэн адил, гэхдээ зөвхөн хорогдуулгын зардал гараагүй тохиолдолд хааж болно.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

### Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг. Түүхэн өртгөөр тодорхойлогдсон гадаад валютаарх мөнгө, мөнгө болон хөрвөх хөрөнгө ба өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлнэ. Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр бүртгэгдсэн мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг уг хөрөнгө, өр төлбөрийн анх үүссэн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Харин гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээр бүртгэгдсэн мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг уг хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг.

### Санхүүгийн хэрэгслүүд

***(i) Ангилал***

Арилжаалах зориулалтын санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь Группын богино хугацааны дотор худалдах зорилгоор худалдан авч, эзэмшиж байгаа өрийн бичиг, өмчийн үнэт цаас, болон бусад үнэт цааснуудаас бүрддэг. Эдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн үр дүнгээр тусгадаг.

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн үр дүнгээр бүртгэх дериватuвууд нь бодит хамгаалалтын хэрэгсэл гэж нэрлээгүй дериватив гэрээнээс бүрдэнэ. Цэвэр авлага (эерэг бодит үнэ цэнэ) позицитой арилжааны дериватuвууд, худалдан авсан опционуудыг арилжааны хөрөнгөөр бүртгэдэг. Харин цэвэр өглөг (сөрөг бодит үнэ цэнэ)-ийн позицитой арилжааны дериватuвууд болон гаргасан/худалдсан опционуудыг арилжааны өр төлбөрөөр бүртгэдэг.

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг ийнхүү ангилахдаа 1) энэхүү ангилал нь нягтлан бодох бүртгэлийн бодит байдалтай үл нийцэх байдлыг бууруулдаг, цаашлаад арилгадаг, 2) холбогдох санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь ямар нэгэн бүлэг санхүүгийн хөрөнгийн, санхүүгийн өрийн эсвэл хоёулангийн бүлэгт багтдаг ба бичиж баримтжуулсан эрсдлийн менежментийн эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тэдгээрийн үр өгөөжийг бодит үнэ цэнэ дээр нь тулгуурлан үнэлж, удирддаг, 3) иж бүрдэл байх буюу иж бүрдлээс нь салгахгүй байх шалгуурт нийцээгүй дериватив эсэхийг харгалзан үзнэ.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

**Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

***(i) Ангилал (үргэлжлэл)***

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэдэг санхүүгийн өр төлбөрүүдийг бодит үнэ цэнээр тайланд тусгах ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант жилийн үр дүнгээр тусгана.

Богино хугацаанд арилжааны зорилгоор бус харилцагчдад олгосон мөнгийг зээл ба урьдчилгаа гэж үздэг. Зээл ба урьдчилгаа нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаанаас бүрдэх ба буцаан цуглуулах боломжтой дүнгээр буюу эрсдлийн санг хассан дүнгээр тайлагнадаг. Эрсдлийн санг Сангийн Яам ба Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах “ журмын дагуу тооцдог.

Гэрээний хугацаа дуустал эзэмших актив нь тогтмол буюу тодорхой төлбөр бүхий гэрээний тодорхой хугацаатай, Групп нь хугацааг дуустал эзэмших, эзэмшиж чадах ба анхнаасаа арилжааны болон арилжаалах боломжтой гэж тогтоон заагаагүй дерватив бус санхүүгийн хөрөнгө юм. Ийм санхүүгийн хөрөнгөд Группын эзэмшиж буй хөрөнгө оруулалтын үнэт цааснууд багтана.

Арилжаалах боломжтой хөрөнгө гэж арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа болон гэрээний хугацааг дуустал эзэмших активаас бусад санхүүгийн хөрөнгийг хэлнэ.

***(ii) Анхдагч хүлээн зөвшөөрөлт***

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэх ба бодит үнэ цэнийг нь тухайн жилийн үйл ажиллагааны ашиг алдагдлаар бүртгэхгүй хөрөнгө ба өр төлбөрийн хувьд бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой гарсан зардлыг нэмж бүртгэнэ.

***(iii) Дараах үеийн хүлээн зөвшөөрөлт***

Бүх арилжааны санхүүгийн хөрөнгө, өр, бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тайлант жилийн ашиг алдагдлаар тусгадаг дерватив, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд, арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх бүртгэлд тусгаснаас хойш бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэнэ. Харин идэвхитэй зах зээл дээр зарлагадсан үнэ ханшгүй ба бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй санхүүгийн хөрөнгө, өрийг өртөг ба ажил гүйлгээний өртөг зардлын нийлбэрээс үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайланд тусгана.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

***(iii) Дараах үеийн хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)***

Арилжааны хэрэгслүүд болон арилжаалах боломжтой хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх ашиг алдагдлыг орлогын тайлан болон эзэмшигчийн өмчийн хэсэгт тус тус тусгана.

Арилжааны бус санхүүгийн өр, зээл болон авлагууд, гэрээний хугацаа дуусах хүртэл эзэмших хөрөнгүүдийг хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэдэг. Хорогдуулсан өртөгийг бодит хүүгийн аргаар тооцон хорогдуулна. Урамшуулал ба хөнгөлөлт, ажил гүйлгээний өртгийг тухайн хэрэгслийн дансны үнэд оруулах ба бодит хүүгийн хувь хэмжээнд үндэслэн хорогдуулдаг.

**Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах**

***(i) Санхүүгийн хөрөнгө***

Групп тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг эзэмших гэрээний эрхээ бусдад шилжүүлсэн, эсвэл уг мөнгөн гүйлгээг нэг ба түүнээс дээш этгээдэд тодорхой шалгуур хангасан тохиолдолд төлөх үүрэг хүлээх болсон, эсвэл хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг бусдад бодитойгоор шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

Группын хувьд өмнө нь бүртгэлдээ тусгасан байсан санхүүгийн хөрөнгийг бусдад шилжүүлэх боловч тэдгээр санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдэлийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдол байдаг. Харин санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой өгөөж болон эрсдлийг шилжүүлээгүй ч бас өөртөө хадгалж үлдээхгүйгээр тохирсон хэлцлийн хувьд тухайн хөрөнгийг хяналт тавьж чадахгүй тухайлбал тухайн шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдаж чадахгүй болсон бол шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлээс хасдаг. Харин хөрөнгөнд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Групп уг хөрөнгийг өөрийн оролцооны хэр хэмжээгээр өөрөөр хэлбэл шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд хэдий хэмжээгээр өртсөн хэвээр байгаа хувь хэмжээгээр нь бүртгэлдээ хэвээр үлдээнэ.

Дээрх бүртгэлээс хасах шалгуурыг заавал тухайн хөрөнгийн хувьд бүхэлд нь эсвэл бүлэг ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгийн хувьд хэрэглэнэ гэхээсээ илүү хэрвээ тохиромжтой бол хөрөнгийн зарим хэсгийг хэсэгчлэн шилжүүлэх үед ч баримтална. Хөрөнгийн хэсгийг шилжүүлэхэд тэрхүү хэсэг нь тусгайлан тогтоосон мөнгөн урсгал, тухайн хөрөнгийн тодорхой хувь хэсэг эсвэл тусгайлан тогтоосон мөнгөн урсгалын тодорхой хувь хэсэг байх ёстой.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах (үргэлжлэл)**

***(ii) Санхүүгийн өр төлбөр***

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд бүртгэлээс хасна. Хэрэв одоогийн санхүүгийн өрийг хуучин зээлдүүлэгчээсээ өөр санхүүгийн өрийн хэрэгслээр солих тохиолдолд шинэ санхүүгийн өрийг хуучнаас нь өөр нөхцлөөр эсвэл одоогийн нөхцлийг нэлээд өөрчилсөн бол хуучин өрийг бүртгэлээс хасч шинэ өрийг бүртгэлд тусгах ба хоёр өрийн бүртгэлийн үнийн зөрүүг иж бүрэн орлогын тайланд тусгана.

**Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс**

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь касс дахь бэлэн мөнгө болон анхны гэрээний хугацаа нь гурван сараас богино бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд бага өртдөг ба богино хугацааны үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг, хязгаарлагдаагүй, банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

**Үндсэн хөрөнгө**

***(i) Хүлээн зөвшөөрөлт, дараах үеийн үнэлгээ***

Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдаж авсан үнэ, импортын татвар, нөхөн олгохгүй худалдан авалтын бусад татварууд болон хөрөнгийг байршуулах газар болон зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах зардлаас бүрддэг. Анх бүртгэлд тусгаснаас хойш бодит үнэ цэнийг нь найдвартай тодорхойлох боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлгээний дүнгээр буюу дахин үнэлгээ хийсэн өдрийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг ашиглалтанд оруулснаас хойш гарсан зардлуудыг тухайлбал засвар үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан жилийн үр дүнгийн тайланд тусгадаг. Харин тухайн зардал гарснаар хөрөнгийг анх авах үеийн тооцоолсон бүтээмж нэмэгдэж, хөрөнгөөс олох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлсэн гэдэг нь тодорхой батлагдаж байвал гарсан зардлыг хөрөнгийн өртөг дээр нэмж капиталжуулна.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

### Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

***(i) Хүлээн зөвшөөрөлт, дараах үеийн үнэлгээ (үргэлжлэл)***

Групп нь дахин үнэлгээнд хамрагдсан үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг зөрүүтэй болгохгүйн тулд үндсэн хөрөнгөө дахин үнэлдэг. Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлгээний нөөц дансанд тусгана. Харин дахин үнэлгээний бууралтыг тухайн хөрөнгийн хувьд үүссэн өмнөх жилийн нэмэгдлийн дүнг тэг болтол дахин үнэлгээний нөөц дансыг бууруулна. Бусад бүх тохиолдолд дансны үнийн бууралтыг иж бүрэн орлогын тайланд тусгана.

***(ii) Элэгдэл***

Үндсэн хөрөнгийг шулуун шугамын аргаар тэдгээрийн тооцоолсон ашиглагдах жилээр элэгдүүлж иж бүрэн санхүүгийн тайланд тусгадаг ба тооцоолсон ашиглагдах жилүүд дараах байдалтай байна.

- Барилга — 40 жил
- Конторын тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл — 10 жил
- Компьютер — 3-5 жил

### Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга гэж шинээр барьж эхэлсэн боловч ашиглалтанд ороогүй байгаа барилгын өртөг юм. Барилгын барьж буй хугацаанд дуусаагүй барилгад элэгдэл тооцоогүй болно.

### Биет бус хөрөнгө

***(i) Худалдан авсан биет бус хөрөнгө***

Группын худалдан авсан биет бус хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон бусад үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнасан.

***(ii) Хорогдуулалт***

Ашиглагдах хугацаа тодорхой биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар тэдгээрийн тооцоолсон ашиглагдах жилээр хорогдуулж иж бүрэн орлогын тайланд тусгадаг. Тооцоолсон ашиглагдах жил дараах байдалтай байна.

- Программ хангамж, лиценз — 3 жил

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

### Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Группын активын дансдад үнэ цэнийн бууралт үүссэн шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд тайлант хугацааны эцэст активын дансдын бүртгэлийн дүнг үнэлж, хянадаг. Хэрвээ үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл тухайн активын нөхөн төлөгдөх үнэ цэнийг тооцоолдог.

***(i) Зээл ба урьдчилгаа***

Зээл ба урьдчилгааг зээлийн болзошгүй алдагдлын санг хассан дүнгээр тайлагнадаг. Болзошгүй алдагдлын санг зээл ба урьдчилгааны үлдэгдэлд хийдэг байнгын хяналт шалгалтын үр дүнд үнэ цэнэ буурсан буюу муудсан гэж тогтоосон зээл ба урьдчилгааны дансны үнийг Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан “Активыг ангилах, активын эрсдлийн санг байгуулах” журмын дагуу тодорхойлсон эргэн төлөгдөх дүн хүртэл нь бууруулан байгуулдаг. Болзошгүй алдагдлын санг нэмэгдүүлэх бичилтийг иж бүрэн орлогын тайланд тусгадаг. Зээл төлөгдөхгүй нь тодорхой болж, бүх шүүх, эрх зүйн арга хэмжээнүүдийг гүйцэтгэж, эцсийн алдагдлын хэмжээг тогтоосон тохиолдолд зээлийг данснаас хасна.

Монголбанкны Эрсдлийн сан байгуулах журмын дагуу Групп нь активын хугацааны ба чанарын үзүүлэлтүүд дээр үндэслэн хүчин зүйлсийг тооцон ангилж, эрсдлийн санг байгуулдаг. Энэхүү аргачлалын дагуу зээлийг ангилах ба хэвийн зээлд 0%, хугацаа хэтэрсэн зээлд 5%, хэвийн бус зээлд 25%, эргэлзээтэй зээлд 50%, муу зээлд 100%-иар тус тус эрсдлийн санг байгуулдаг. СТОУС-ын дагуу хорогдуулсан өртгөөр хэмжигддэг активын үнэ цэнийн бууралтыг тухайн хөрөнгийн дансны үнэ ба хөрөнгийн анх үүсэх үеийн бодит хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр тодорхойлдог.

Зээлийг чанарын үзүүлэлтүүдээр ангилахад зээлийн баримтын бүрдүүлэлт, зээлдэгчийн санхүүгийн үзүүлэлтүүд, барьцаа хөрөнгийн үнэлгээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрчилсөн эсэх зэргийг харгалзан үздэг.

Хэрвээ хожим нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг бууруулах үйл явдал гарвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаах байдлаар иж бүрэн орлогын тайланд тусгана.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

***(ii) Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс, зээл ба урьдчилгаанаас бусад актив***

Групп тухайн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст үнэлж тодорхойлдог. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинэ тэмдэг илэрвэл эсвэл тухайн хөрөнгийн хувьд жил бүр үнэ цэнийн бууралтыг үнэлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн хөрөнгийн ирээдүйд нөхөн төлөгдөх дүнг тооцоолдог. Нөхөн төлөгдөх дүн нь тухайн хөрөнгийн буюу мөнгө үүсгэгч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн ба ашиглагдах үеийн үнэ цэнийн аль ихээр тодорхойлогдоно. Ашиглагдах үеийн үнэ цэнийг тодорхойлохдоо тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтласан өнөөгийн үнэ цэнээр тогтооно. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой үүсэх эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Бусад хөрөнгүүдээс хамааралгүйгээр бие даасан мөнгөн урсгалыг бий болгодоггүй хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн харъяалагдах мөнгө үүсгэгч нэгжийн хувьд нөхөн төлөгдөх дүнг тодорхойлно. Мөнгө үүсгэгч нэгж буюу хөрөнгийн дансны үнэ нь нөхөн төлөгдөх дүнгээс их байвал үнэ цэнийн бууралтын алдагдал үүсгэнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг иж бүрэн орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Нөхөн төлөгдөх дүнг тооцоход ашигласан үнэлгээ, тооцоололд өөрчлөлт гарсан тохиолдолд үнэ цэнийн алдагдлыг буцаадаг. Ингэхдээ хөрөнгийн байх байсан дансны үнэ буюу өмнөх үнэ цэнийн бууралтыг оруулахгүйгээр тооцвол байх байсан хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлэхгүй байхаар тооцоолж буцаана. Үнэ цэнийн алдагдлын буцаалтын бичилтийг иж бүрэн орлогын тайланд тусгадаг.

**Буцаан худалдан авалтын гэрээнүүд**

Групп нь хоорондоо ижил төстэй хөрөнгө оруулалтыг ирээдүйд тогтмол үнээр, тогтоосон хугацаанд дахин худалдах (худалдан авах) зорилгоор хөрөнгө оруулалтыг худалдан авах (борлуулах) гэрээ хийдэг. Ирээдүйд буцаан худалдах үүрэгтэй тул худалдан авсан хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд тусгахгүй. Харин тэдгээрийг худалдан авахад төлсөн дүнгээр банк болон харилцагчдад олгосон зээл гэж бүртгэдэг. Зээлийн авлагыг худалдан авсан үнэт цаасаар баталгаажсан гэж үзнэ. Репо гэрээний дагуу худалдсан хөрөнгө оруулалтыг балансаас хасахгүй ба арилжааны эсвэл арилжаалах боломжтой хөрөнгийн аль тохирохоор бүртгэж, тайлагнана. Хөрөнгө оруулалтыг худалдсанаар хүлээн авсан мөнгийг бусад банк эсвэл харилцагчдад төлөх өр гэж бүртгэнэ. Хөрөнгө оруулалтыг худалдах, буцаан худалдан авсанаас үүсэх зөрүүг хүүгийн орлого эсвэл зардал гэж бүртгэх ба гэрээний хугацааны туршид бодит хүүгийн аргаар хуримтлуулан бүртгэдэг.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

### Хувьцаат капитал

***(i) Энгийн хувьцаа***

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Энгийн хувьцаа, энгийн хувьцааны опцион гаргахтай шууд холбоотой гарсан зардлуудыг татварыг нь суутгасан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг.

***(ii) Халаасны хувьцаа***

Өөрийн хөрөнгөөр бүртгэсэн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авахдаа төлсөн, ийнхүү худалдан авахтай холбоотой гарсан бүх зардлуудыг, татварыг нь хассан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаагаар ангилах ба нийт өөрийн хөрөнгийн бууралт байдлаар харуулдаг. Харин халаасны хувьцааг дахин гаргасан, худалдсан бол хүлээн авсан мөнгөн дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ба тухайн гүйлгээнээс бий болсон илүү ба дутуугийн зөрүүг хуримтлагдсан ашгаас нөхөх эсвэл ашгийг нэмэгдүүлэх байдлаар залруулдаг.

### Нөөцийн сан

Групп нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл засаж сайжруулахаар үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бол нөөцийн санг балансад тусгадаг. Мөнгөний цаг хугацааны нөлөөлөл өндөр бол ирээдүйн мөнгөн зарлагын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан сангийн дүнг тодорхойлно. Дискаунтын хувь нь мөнгөнийн цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн өр төлбөртэй холбоотой эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой.

### Сегментийн тайлагнал

Үйл ажиллагааны сегмент нь бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хийсэн ажил гүйлгээ болон бизнесийн үйл ажиллагаа эрхлэсэнээс орлого олж, зарлага гаргадаг Группын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Бүх сегментүүдийн үйл ажиллагааны үр дүнг Компанийн гүйцэтгэх үйл ажиллагааны шийдвэр гаргагч (“ГҮАШГ”) тогмол хянаж, сегментэд хуваарилагдах нөөцийг тодорхойлох, гүйцэтгэлийг болон санхүүгийн мэдээллийг салган харах боломж зэргийг үнэлдэг.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

**Орлого**

***(i) Хүүгийн орлого***

Хүүгийн орлого ба зардлыг аккруэль сууриар иж бүрэн орлогын тайланд тусгадаг ба хөрөнгийн бодит үр өгөөжийг харгалздаг. Хүүгийн орлого ба зардал нь хөнгөлөлт, урамшууллын хорогдол буюу хүүтэй зээлийн хэрэгслийн дансны үнэ ба бодит хүүгийн аргаар хорогдуулсаар төлөгдөх хугацааны эцэст гарах дүн хоорондын зөрүүгээс бүрдэнэ. Гэхдээ Групп нь зээл анх олгох өртөг зардал болон үйлчилгээний шимтгэлийг бодит хүүгийн аргаар хорогдуулахгүй, шууд тайлант жилийн үйл ажиллагааны орлого, зардлаар бүртгэдэг.

***(ii) Хураамж, шимтгэлийн орлого***

Хураамж, шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлбөр юм. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсэн үед орлогоор бүртгэнэ.

***(iii) Түрээсийн орлого***

Түрээсийн орлогыг түрээсийн гэрээний хугацааны туршид нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн орлогын бүрдэл хэсэг гэж үздэг.

**Үйл ажиллагааны түрээсийн төлбөр**

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн гэрээний хугацааны туршид нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд шулуун шугамын аргаар бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын бүрдэл хэсэг гэж үзэх ба түрээсийн гэрээний хугацааны туршид хорогдуулан бүртгэнэ.

**Орлогын албан татвар**

Орлогын албан татвар нь зөвхөн тайлант жилд ноогдуулсан орлогын албан татвараас бүрдэнэ.

Тайлант жилийн татвар гэдэг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод балансын өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын хүлээгдэж буй өр эсвэл авлага болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

### Орлогын албан татвар (үргэлжлэл)

2010 оны 5 дугаар сард Сангийн яамнаас хойшлогдсон татварын зөрүүг зохицуулах тухай журам гарсан. Гэвч Монгол улсын татварын алба уг журмыг хэрэгжүүлж эхлээгүй, Татварын хууль тогтоомжид оруулж, тусгаагүй ба энэ нь аж ахуйн нэгжүүд, арилжааны банкууд, болон татварын байгууллагууд хойшлогдсон татварын талаарх мэдлэг бага байгаатай холбоотой. Энэ журмыг хэрэглэж эхлэхийн тулд журам, аргачлал гаргах, татварын зөвлөхүүдтэй ярилцлага хийх, сургалт зохион байгуулах шаардлагатай байна. Монголбанк нь хойшлогдсон татварын өр, хөрөнгийг тооцоолох журам аргачлал боловсруулахаар төлөвлөж байгаа ба арилжааны банкуудын хойшлогдсон татварын хөрөнгө, өрийн бүртгэл СТОУС-д нийцэхгүй байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа болно.

### Ажилчдын тэтгэмж

Групп нь улсын нийгмийн даатгалын системд ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийг олгодоггүй. Группээс төлөх ажил олгогчийн шимтгэлийг төлөхөөр хуримтлуулсан жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

### Ноогдол ашиг

Ноогдол ашгийг зарласан тайлант хугацааны санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэдэг.

### Группд хэрэгжүүлээгүй байгаа шинээр гарсан СТОУС-ууд ба тэдгээрийн тайлбарууд

Дараах хэд хэдэн стандарт, тэдгээрийн тайлбарууд шинээр гарсан, өөрчлөгдсөн боловч тэдгээр нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр болоогүй тул энэхүү санхүүгийн тайланг бэлтгэхэд хэрэглээгүй болно.

- 2011 оны 6 дугаар сард Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хороо НББОУС 1 Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгад нэмэлт өөрчлөлт оруулсан нь бусад дэлгэрэнгүй орлогын зүйлсүүдийг бүлэглэн орлогын зүйлсүүдийг бүлэглэн орлогын тайланд дахин ангилахаар тусгасан. Нэмэлт өөрчлөлтийн шаардлага нь бусад дэлгэрэнгүй орлогын зүйлс болон ашиг алдагдал нь нэг эсвэл тус тусдаа тайлан байх явдал юм. Одоогийн байдлаар Групп нь эдгээр стандартын өөрчлөлт нь нэгтгэсэн санхүүгийн тайланд ямар нөлөөтэй эсэхийг үнэлж, судалж байна.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (үргэлжлэл)

**Группд хэрэгжүүлээгүй байгаа шинээр гарсан СТОУС-ууд ба тэдгээрийн тайлбарууд (үргэлжлэл)**

- 2011 оны 5 дугаар сард Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хороо нь СТОУС 10 гарсантай холбогдуулан СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан, СТОУС 11 Хамтарсан хэлцэл, СТОУС 12 Бусад байгууллагад оруулсан хөрөнгийн тодруулга болон НББОУС 27 Салангид санхүүгийн тайлан-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба салангад санхүүгийн тайлан бэлтгэх зааварт өөрчлөлт ороогүй бөгөөд НББОУС 28 Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт нь СТОУС 10 болон 11-д хийгдсэн өөрчлөлтийг дагуу нэмж тодруулсан.

  Дээрхи стандартууд нь 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Хэдийгээр СТОУС 12 хүчин төгөлдөр үйлчилж эхлээгүй ч гэсэн тухайн стандартын дагуу байгууллагууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгыг хийхийг зөвшөөрсөн. Одоогийн байдлаар Групп нь эдгээр стандартын өөрчлөлт нь нэгтгэсэн санхүүгийн тайланд ямар нөлөөлөлтэй эсэхийг үнэлж, судалж байна.

- 2011 оны 5 дугаар сард Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хороо нь СТОУС хүрээнд зах зээлийн үнийн хэмжилтийн талаархи заавчилгаа болдог СТОУС 13 Зах зээлийн үнийн хэмжилт гаргасан. Уг стандарт нь бодит үнэ цэнийг тодорхойлсон бөгөөд бодит үнэ цэнийн хэзээ, ямар тохиолдолд хэрэглэх заавар нь бусад СТОУС-д тусгагдсан учир бодит үнэ цэнийн хэмжилтийн талаар илүү дэлгэрэнгүй тодруулж тусгасан. СТОУС 13 нь 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Одоогийн байдлаар Групп нь эдгээр стандартын өөрчлөлт нь нэгтгэсэн санхүүгийн тайланд ямар нөлөөлөлтэй эсэхийг үнэлж, судалж байна.

## 4. БЭЛЭН МӨНГӨ БА БАНК ДАХЬ МӨНГӨН ХӨРӨНГӨ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Касс дах бэлэн мөнгө | 55,558,591 | 50,082,881 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө | 138,718,842 | 168,120,730 |
| Монголбанк дахь харилцах (*) | 250,535,821 | 256,761,023 |
| | 444,813,254 | 474,964,634 |

(*) 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкны шаардлагын дагуу харилцагчаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хоёр долоо хоногийн дундаж үлдэгдлийн 12 хувь (2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 11 хувь байсан)-иас багагүй нөөцийг Монголбанкинд байршуулах ёстой бөгөөд 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар заавал байх нөөцийн дүн 168,064,650 мянган төгрөг болон 255,054,560 мянган төгрөг байна. Өдрийн дундаж үлдэгдлийн хувьд Групп нь өдөр бүрийн эцэст заавал байлгах нөөцийн 50 хувиас багагүй дүнг байлгах ёстой.

## 5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮНЭТ ЦААС

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| **Арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас** | | |
| Хаалттай компанийн өмчийн үнэт цаас, өртгөөр (*1) | 1,527,104 | 14,136,462 |
| Өмчийн үнэт цаас, зах зээлийн үнээр (*2) | 47,462,745 | 24,846,858 |
| Монголбанкны үнэт цаас (*3) | 46,183,485 | 199,298,305 |
| | 95,173,334 | 238,281,625 |
| **Арилжаалах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас** | | |
| Засгийн газрын бонд | 359,931,276 | 103,332,743 |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (*4) | 1,697,000 | 2,653,000 |
| | 361,628,276 | 105,985,743 |
| | 456,801,610 | 344,267,368 |

## 5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮНЭТ ЦААС (үргэлжлэл)

(*1) Хаалттай компанид оруулсан хөрөнгө оруулалт нь хөрөнгийн биржид бүртгэлгүй компаниудад оруулсан хөрөнгө оруулалтууд бөгөөд өртгөөр нь бүртгэсэн. Тэдгээрийг нийтэд арилжаалдаггүй тул бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй ба тооцооллын зөрүү маш их гарна гэж үзэж байна.

(*2) 2012 оны тайлант жилд Групп өмчийн үнэт цаас худалдан авч арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын хувьцаа гэж ангилсан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр энэхүү хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн 22,071,596 мянган төгрөгийн хүлээн зөвшөөрөгдөөгүй олзыг өмчид бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнасан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дээрх өмчийн үнэт цааснуудын 2,264,827 мянган төгрөг нь бодит үнэ цэнийн 1 дүгээр түвшинд 42,933,091 мянган төгрөг нь 3 дугаар түвшинд байна.

(*3) Групп Монголбанкны үнэт цаасыг хугацаа нь дуусахаас өмнө борлогдох боломжтой гэж үзэн арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж ангилсан. 2011 он болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Монголбанкны үнэт цаасны бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо байсан учир хүлээн зөвшөөрөгдөөгүй олз гарз үүсээгүй. 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр уг хөрөнгийн бодит үнэ цэнэ 2 дугаар түвшинд байна.

(*4) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монголын Ипотекийн Корпораци ХХК-аас (МИК) гаргасан үнэт цаасыг илэрхийлнэ.

## 6. ХАРААТ КОМПАНИ ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| МИК ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*1) | 2,385,599 | 2,275,956 |
| ТиДиБи Медиа ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт (*2) | - | - |

(*1) Групп нь 2009 онд Монголын Ипотекийн Корпорацийн нийт энгийн хувьцааны 9.1 хувийг худалдан авч 201,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн ба энэ нь 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад хамаарч байна. Групп 2011 оны 8 дугаар сарын 4-нд 2,000,001 мянган төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт хийснээр Группын Монголын Ипотекийн Корпораци дахь өмчлөлийн хувь нь өсч ойролцоогоор 31.6% болсон.
2011 оны 8 дугаар сарын 04-ны өдрөөс эхлэн Групп МИК-д оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар бүртгэж, 2012 болон 2011 онуудад тус тус 109,644 мянга болон 74,955 мянган төгрөгийн ашгийн ноогдох хувийг хүлээн зөвшөөрсөн.
Одоогоор Монголын Ипотекийн Корпораци нь арилжааны банкуудын гаргасан ипотекийн зээлийг худалдан авч, ипотекийн үнэт цаас гаргаж байна.

## 6. ХАРААТ КОМПАНИД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (үргэлжлэл)

(*2) 2012 онд ТиДиБи Медиагийн хувьцааны 49 хувийг 2,450,000 мянган төгрөгөөр авсан. Мөн 2012 онд ТиДиБи Медиагийн хувьцааны алдагдлаар 2,450,000 мянган төгрөг бүртгэсэн. ТиДиБи Медиагийн 2012 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн мэдээлллийг ашиглаж өмчийн аргыг хэрэглэсэн.

2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ээрх хараат компаниудын хураангуй санхүүгийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

| Санхүүжигч | **2012 Мян.төг** | | **2011 Мян.төг** | |
|---|---|---|---|---|
| | Хөрөнгө | Өр төлбөр | Хөрөнгө | Өр төлбөр |
| Монголын Ипотекийн Корпораци | 18,344,787 | 10,809,499 | 11,582,366 | 4,389,081 |
| ТиДиБи Медиа | 4,382,508 | 4,396,561 | - | - |

| Санхүүжигч | **2012 Мян.төг** | | **2011 Мян.төг** | |
|---|---|---|---|---|
| | Үйл ажиллагааны орлого | Цэвэр ашиг | Үйл ажиллагааны орлого | Цэвэр ашиг |
| Монголын Ипотекийн Корпораци | 2,362,788 | 427,121 | 1,101,881 | 125,841 |
| ТиДиБи Медиа | 40,356 | (5,024,054) | - | - |

## 7. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ЦЭВЭР)

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,530,158,608 | 1,131,816,506 |
| Гүйцэтгэх удирдлага, захирлууд болон ажилчдад олгосон зээл | 16,605,055 | 9,435,210 |
| | 1,546,763,663 | 1,141,251,716 |
| Зээлийн болзошгүй эрсдлийн сан | (13,491,840) | (17,919,809) |
| Зээл ба урьдчилгааны цэвэр дүн | 1,533,271,823 | 1,123,331,907 |

Тайлант жилийн зээлийн болзошгүй эрсдлийн сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 17,919,809 | 14,003,824 |
| Эрсдлийн зардлаар нэмж байгуулсан болон нөхөлтөөр буурсан | (4,305,104) | 3,976,213 |
| Эрсдлийн сангаас хаасан зээл | (122,865) | (60,228) |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 13,491,840 | 17,919,809 |

2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 556,851,619 мянган төгрөг ба 842,460,378 мянган төгрөгийн үлдэгдэл бүхий зээл ба урьдчилгаа нь тайлангийн өдрөөс хойш 12 сараас илүү хугацааны дараа төлөгдөхөөр хүлээгдэж байна.

**Ипотекийн зээлийн багц шилжүүлэх тухай**

2008 онд Групп нь нийт 404,864,410 төгрөг ба 294,334 ам.долларын дансны үнэ бүхий ипотекийн зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци ХХК (цаашид МИК гэх)-д бэлэн мөнгөөр солилцож шилжүүлсэн. 2009 онд Групп нь нийт 4,700,819,887 төгрөгийн дансны үнэ бүхий ипотекийн зээлийн багцыг МИК-ээс гаргасан бондоор солилцож шилжүүлсэн. 2009 оноос хойш ипотекийн зээлийн багц МИК-д шилжүүлээгүй болно.

Буцаан солих нөхцөлтэйгээр шилжүүлсэн зээлүүд нь тэдгээрээс үүсэх эрсдэл ба өгөөжийг МИК-д бүрэн шилжүүлээгүй тул бүртгэлээс хасах шалгуурыг хангаагүй. Буцаан солих нөхцөл нь холбогдох зээлийн худалдан авалтын гэрээнд зааснаар Групп өмнөх шилжүүлсэн ипотекийн зээлийг хэвийн зээлээр солих юм. Иймээс эдгээр гүйлгээг барьцаатай зээллэг гэж бүртгэсэн.

## 7. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (үргэлжлэл)

2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өглөгийн дансны үнэ болон бодит үнэ цэнэ дараах байдалтай байна.

| | **2012 Мян.төг** | **2012 Мян.төг** |
|---|---|---|
| Дансны үнэ | | |
| Шилжүүлсэн хөрөнгө | 1,531,618 | 2,197,608 |
| Холбогдох өглөг | (1,531,618) | (2,197,608) |
| Бодит үнэ цэнэ | | |
| Шилжүүлсэн хөрөнгө | 1,693,222 | 2,397,445 |
| Холбогдох өглөг | (1,693,222) | (2,397,445) |
| Цэвэр | - | - |

## 8. БУЦААН ХУДАЛДАХ ГЭРЭЭГЭЭР АВСАН ҮНЭТ ЦААС

| **Харилцагч банк** | **Худалдан авсан огноо** | **Дуусах огноо** | **Хүүгийн түвшин** | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар хотын банк | 2011.12.30 | 2012.01.02 | 11% | - | 36,966,114 |

Групп нь 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар хотын банктай байгуулсан “Буцаан худалдах болон худалдан авах гэрээ”-гээр 37,000,000 мянган төгрөгийн Монголбанкны үнэт цаасыг буцааж худалдах нөхцөлтэйгөөр тус банкнаас худалдан авсан. Энэхүү худалдан авсан үнэт цаас нь тухайн гэрээний зүйл болох авлагын барьцаа байна. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Групп буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаасгүй байна.

## 9. ХОЁРДОГЧ ЗЭЭЛ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Улаанбаатар хотын банк | 4,000,000 | 4,000,000 |
| Капитрон банк | 3,000,000 | 3,000,000 |
| | 7,000,000 | 7,000,000 |

Улаанбаатар хотын банкинд олгосон зээл нь жилийн 8 хувийн тогтмол хүүтэй, 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр бүрэн төлж дуусгах нөхцөлтэй ба Капитрон банкинд олгосон зээл нь жилийн 12 хувийн тогтмол хүүтэй, 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдөр бүрэн төлөх нөхцөлтэй байна.

## 10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВЭР)

2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилүүдийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

**2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр**

***(Мянган төгрөгөөр)***

| | Барилга | Машин, тоног төхөөрөмж | Компьютер, дагалдах хэрэгсэл | Дуусаагүй барилга | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Өртөг/ Дахин үнэлгээ** | | | | | |
| Өртөгөөр | 5,157,931 | 4,858,084 | 5,507,828 | 52,329,613 | 67,853,456 |
| Дахин үнэлгээгээр | 18,555,196 | - | 146,870 | - | 18,702,066 |
| 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | 23,713,127 | 4,858,084 | 5,654,698 | 52,329,613 | 86,555,522 |
| Нэмэгдсэн | 28,395,617 | 1,039,864 | 3,357,649 | 22,550,692 | 55,343,822 |
| Худалдсан | - | (326,572) | (330) | (220,018) | (546,920) |
| Данснаас хассан | (1,752,037) | (192,843) | (319,347) | - | (2,264,227) |
| Шилжүүлсэн | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээ | - | - | - | - | - |
| 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 50,356,707 | 5,378,533 | 8,692,670 | 74,660,287 | 139,088,197 |
| Үүнээс: | | | | | |
| Өртөг | 31,801,511 | 5,378,533 | 8,692,670 | 74,660,287 | 120,533,001 |
| Дахин үнэлгээ | 18,555,196 | - | - | - | 18,555,196 |
| | 50,356,707 | 5,378,533 | 8,692,670 | 74,660,287 | 139,088,197 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | | |
| 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | 1,752,037 | 2,027,008 | 3,631,485 | - | 7,410,530 |
| Нэмэгдсэн | 974,265 | 466,489 | 1,001,035 | - | 2,441,789 |
| Худалдсан | - | (119,463) | (147) | - | (119,610) |
| Данснаас хассан | (1,752,037) | (178,039) | (305,435) | - | (2,235,511) |
| 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 974,265 | 2,195,995 | 4,326,938 | - | 7,497,198 |
| **Үлдэгдэл өртөг** | | | | | |
| 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 49,382,442 | 3,182,538 | 4,365,732 | 74,660,287 | 131,590,999 |

## 10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВЭР) (үргэлжлэл)

### 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

***(Мянган төгрөгөөр)***

| | Барилга | Машин, тоног төхөөрөмж | Компьютер, дагалдах хэрэгсэл | Дуусаагүй барилга | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **Өртөг/ Дахин үнэлгээ** | | | | | |
| Өртөгөөр | 4,007,918 | 3,820,957 | 4,073,437 | 336,651 | 12,238,963 |
| Дахин үнэлгээгээр | 13,271,406 | - | 146,870 | - | 13,418,276 |
| 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | 17,279,324 | 3,820,957 | 4,220,307 | 336,651 | 25,657,239 |
| Нэмэгдсэн | 1,472,719 | 1,037,127 | 1,434,721 | 52,088,745 | 56,033,312 |
| Худалдсан | (275,209) | - | - | - | (275,209) |
| Данснаас хассан | - | - | (330) | - | (330) |
| Шилжүүлсэн | 95,783 | - | - | (95,783) | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлээр | 5,140,510 | - | - | - | 5,140,510 |
| 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 23,713,127 | 4,858,084 | 5,654,698 | 52,329,613 | 86,555,522 |
| Үүнээс: | | | | | |
| Өртөг | 5,157,931 | 4,858,084 | 5,507,828 | 52,329,613 | 67,853,456 |
| Дахин үнэлгээ | 18,555,196 | - | 146,870 | - | 18,702,066 |
| | 23,713,127 | 4,858,084 | 5,654,698 | 52,329,613 | 86,555,522 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | | |
| 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | 1,281,970 | 1,614,474 | 2,949,711 | - | 5,846,155 |
| Нэмэгдсэн | 637,531 | 412,534 | 681,802 | - | 1,731,867 |
| Худалдсан | (23,559) | - | - | - | (23,559) |
| Данснаас хассан | - | - | (28) | - | (28) |
| Дахин үнэлгээ | (143,905) | - | - | - | (143,905) |
| 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 1,752,037 | 2,027,008 | 3,631,485 | - | 7,410,530 |
| **Үлдэгдэл өртөг** | | | | | |
| 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 21,961,090 | 2,831,076 | 2,023,213 | 52,329,613 | 79,144,992 |

## 10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВЭР) (үргэлжлэл)

Групп нь орон сууц болон компьютеруудыг 2011 болон 2012 онуудад худалдсан. Тухайн хөрөнгүүдийн дахин үнэлгээний үр дүнгээр бүртгэсэн 624 мянган төгрөг болон 146,870 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 2011 болон 2012 онуудын хуримтлагдсан ашигт хаасан.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь Улаанбаатар хотод баригдаж буй Группын оффисын барилгын өртгийг илэрхийлнэ. Группын оффисын барилгын ажил нь 2011 оны 2 дугаар улиралд эхэлсэн бөгөөд 2013 оны 4 дүгээр улиралд дуусахаар хүлээгдэж байна. 2011 болон 2012 онд үндсэн хөрөнгө худалдан авах зориулалтаар авсан зээлийн хүүг капиталжуулж бүртгээгүй болно.

Хараат бус, мэргэжлийн үнэлгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн барилгын хамгийн сүүлийн үеийн үнэлгээний дэлгэрэнгүйг дор үзүүлэв.

| Үнэлгээний огноо | Хөрөнгийн нэр | Үнэлгээний дүн | Үнэлгээний арга |
|---|---|---|---|
| 2008.10.31 | Барилга | 17,076,514 | Зах зээлийн үнэ |
| 2011.12.31 | Барилга | 21,961,090 | Зах зээлийн үнэ |

Хэрэв үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдлийг хассан түүхэн өртгөөр нь бүртгэсэн гэж үзвэл дахин үнэлсэн хөрөнгийн дансны үнэ нь 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдалтай байна. Үүнд:

| | **2012**<br>**Мян.төг** | **2011**<br>**Мян.төг** |
|---|---|---|
| Барилга | 33,456,513 | 3,833,704 |

## 11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВЭР)

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| **Өртөг** | | |
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 2,781,462 | 2,517,126 |
| Нэмэгдсэн | 490,317 | 264,336 |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 3,271,779 | 2,781,462 |
| **Хорогдуулалт** | | |
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 2,348,064 | 1,861,232 |
| Тайлант жилд байгуулсан | 321,884 | 486,832 |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 2,669,948 | 2,348,064 |
| **Үлдэгдэл өртөг** | | |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 601,831 | 433,398 |

Биет бус хөрөнгө нь зөвхөн худалдан авсан программ хангамжаас бүрддэг.

## 12. ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга | 26,500 | 26,500 |
| Орон сууцны зориулалттай барилга | 136,426 | 812,269 |
| Хасах нь: Үнэлгээний хасагдуулга | (5,778) | (259,579) |
| | 157,148 | 579,190 |

Зээл ба урьдчилгааны төлбөрт авсан үндсэн хөрөнгийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэж, арилжаалах боломжтой хөрөнгийн ангилалд оруулдаг. Уг хөрөнгөд Сангийн Яам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулах журмын дагуу үнэ цэнийн бууралтын нөөц байгуулдаг. Энэхүү журмын дагуу Группын өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүдийг хугацааны үзүүлэлтүүдэд үндэслэн 0%, 5%, 25%, 50%, 100% - аар тус тус үнэ цэнийн бууралтын нөөц байгуулдаг. 2011 болон 2012 оны тайлант жилд барьцаанд хураагдсан хөрөнгөнөөс зарж борлуулсантай холбогдуулан 884,864 мянган төгрөг ба 247,463 мянган төгрөгийн нөөцийг тус тус буцаасан ба 2011 онд 82,157 мянган төгрөгийн өмчлөх бусад хөрөнгийг үнэ цэнийн бууралтын нөөцөөс хаасан.

## 13. БУСАД ХӨРӨНГӨ

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| Үнэт металл(*1) | 25,033,389 | 31,151 |
| Хуримтлагдсан хүүгийн авлага | 24,165,543 | 14,929,123 |
| Урьдчилж төлсөн зардал (*2) | 805,450 | 4,439,151 |
| Хангамжийн материал | 829,933 | 490,954 |
| Спот арилжааны авлага (*3) | 65,414,600 | 30,691,100 |
| Бусад авлага (цэвэр) | 7,608,037 | 1,185,751 |
| | 123,856,952 | 51,767,230 |

2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи бусад авлага нь 2,156,497 мянган төгрөг болон 153,689 мянган төгрөгийн болзошгүй эрсдлийн санг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн.

(*1) 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зээлдэгчдийн зээлийн барьцаанд байсан 23,842,597 мянган төгрөгөөр үнэлэгдэх алтан гулдмайг Групп худалдан авсан.

(*2) 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл нь Монголбанкны зөвшөөрөлгүй 2008 оны 4 дүгээр сард "Улаанбаатар хотын банк" ХХК-ийн нийт хувьцааны 10 хувь буюу 800 ширхэг хувьцааны үнэд төлсөн 3,000,000 ам.доллар буюу 3,502,950 мянган төгрөг байсан. 2012 онд уг урдчилж төлсөн зардал нь мөн дүнгээр худалдан авалтын хуваарийн суутгалын дагуу буурсан.

(*3) 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи спот арилжааны авлага, өглөг нь цэвэр дүнгээр тайлагнагдсан. Гэхдээ зөвхөн хуулийн дагуу цэвэр дүнгээр төлбөр тооцоо хийх боломжтой спот гэрээнүүдийг цэвэр дүнгээр тайлагнадаг. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Групп дээрх нөхцлийг хангаагүй спот арилжааны авлага, өглөгөө нийт дүнгээр нь тайлагнасан.

## 14. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| Харилцах данс | 599,471,005 | 524,418,099 |
| Хугацаагүй хадгаламж | 200,121,416 | 206,263,343 |
| Хугацаатай хадгаламж | 579,734,505 | 534,258,396 |
| Бусад хадгаламж | 22,999,837 | 12,356,124 |
| | 1,402,326,763 | 1,277,295,962 |

## 14. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ (үргэлжлэл)

Банк харилцах данс болон зарим хадгаламжид хүү тооцдоггүй боловч тогтоосон хязгаараас дээш хэмжээнд дансныхаа үлдэгдлийг барих шаардлагыг хангасан хадгаламж эзэмшигчдийн гадаад валют болон төгрөгийн хадгаламжид дунджаар жилийн 1.2% ба 3.35% (2011 онд 1 .5% ба 3.4%) хүүг тус тус тооцож, олгодог.

Гадаад валютын болон төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү ойролцоогоор 2.0% ба 6.5% (2011 онд 1.9% ба 6.3%) байна.

Гадаад валютын болон төгрөгийн хугацаатай хадгаламжийн жилийн хүү ойролцоогоор 6.7% ба 12.5% (2011 онд 6.5% ба 12.3%) байна.

## 15. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Харилцах данс: | | |
| Гадаад валютын харилцах | 13,641,083 | 12,361,181 |
| Төгрөгийн харилцах | 88,608 | 99,390 |
| Борлуулах гадаад валютын чек | 223,737 | 249,214 |
| Банкны хадгаламж | 22,565,055 | 22,353,770 |
| | 36,518,483 | 35,063,555 |

## 16. БУЦААН ХУДАЛДАЖ АВАХ ГЭРЭЭГЭЭР БОРЛУУЛСАН ҮНЭТ ЦААС

| **Харилцагч** | **Худалдсан огноо** | **Дуусах огноо** | **Хүүгийн түвшин** | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|---|---|---|
| Кредит банк | 2012.12.26 | 2013.01.02 | 15.00% | 1,495,638 | - |
| Монголбанк | 2011.12.28 | 2012.01.02 | 16.25% | - | 66,816,502 |
| Монголбанк | 2011.12.28 | 2012.01.03 | 16.25% | - | 39,314,997 |
| Монголбанк | 2011.12.30 | 2012.01.02 | 16.25% | - | 65,352,970 |
| | | | | 1,495,638 | 171,484,469 |

Групп нь 2012 болон 2011 онд Кредит банк болон Монголбанктай байгуулсан “Буцаан худалдах гэрээ”-ны дагуу 177,000,000 мянган төгрөг болон 1,500 мянган төгрөгийн Монголбанкны үнэт цаас болон Засгийн газрын бондыг өөр өөр хугацаанд буцаан худалдаж авах нөхцөлтэйгөөр худалдсан. Энэхүү үнэт цаас нь тухайн гэрээгээр үүсэх өр төлбөрийн барьцаа байна.

## 17. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| КФВ төсөл | 5,396,917 | 3,457,600 |
| Дэлхийн банк | 4,841,873 | 6,674,634 |
| Азийн хөгжлийн банк | 1,518,287 | 1,139,259 |
| ОУ-ын хөгжлийн ассоциаци | 731,879 | 750,880 |
| БНСУ-ын Экспорт, импорт банк | 22,154,841 | 18,094,576 |
| Австрийн Ви Ти Би Банк | 10,440,750 | 50,548,594 |
| БНХАУ-ын Экспорт, импорт банк | 694,809 | 148,118 |
| Японы ОУ-ын хамтын ажиллагааны агентлаг | 17,044,943 | 6,640,131 |
| Атлантик банк | 4,518,726 | 3,265,411 |
| ЖДҮХС-ын төслийн эх үүсвэх (Сангийн яам) | 71,457,399 | 74,217,691 |
| Коммерз банк | 1,850,613 | 2,228,909 |
| Industrial and Commercial Bank of China (“ICBC”) | 6,120,880 | 740,110 |
| Ай Эн Жи Банк | 5,955,455 | 848,337 |
| Баошанг банк | 1,912,513 | 3,428,658 |
| Монголын Ипотекийн Корпораци | 1,531,618 | 2,197,608 |
| Сумитомо Мицуй Банк Корпораци | 951,390 | - |
| Нидерланд Хөгжлийн Санхүүгийн Компани | 13,921,000 | - |
| Bank of China (Хонг Конг) | 550,381 | - |
| Монголын Хөрөнгийн Бирж | 1,643,658 | - |
| Чайна Трэйд Солушнс | 78,310 | - |
| Монголбанкны Дэд төсөл | 52,730,928 | - |
| Стандарт Чартерэд Банк | 6,876,914 | - |
| | 232,964,084 | 174,380,516 |

**КФВ төслийн зээл**

ХБНГУ-ын КФВ (KfW) банкны санхүүжилтээр хэрэгжих жижиг дунд үйлдвэрийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг санхүүжүүлэхээр Монголбанкаар дамжуулан тус банкнаас 4,345,981 еврогийн зээлийн эх үүсвэрийг авахаар КФВ (KfW) банктай Зээлийн болон санхүүжилтийн гэрээг 2002 онд байгуулсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн эх үүсвэр нь 1,913,702 евро болон 2,939,770 еврогийн үлдэгдэлтэй байна. Тус зээлийн эх үүсвэр нь 2042 оны 6 дугаар сард дуусах бөгөөд зээлийн хүү нь тогтмол жилийн 1.25 хувь бөгөөд үүний 0.75 хувийг KfW-д, үлдсэн 0.50 хувийг Монголбанкинд төлдөг. Үндсэн зээлийн төлбөрийг хагас жилээр хийдэг ба зээл эргэн төлөх өдөр нь харилцагчдад олгосон өдрөөсөө хамааран харилцан адилгүй байдаг.

## 17. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

**Дэлхийн Банкны зээл**

| | 2012 Мян.төг | 2011 Мян.төг |
|---|---|---|
| Зээл I | 24,568 | 80,498 |
| Зээл II | 4,817,305 | 6,594,136 |
| | 4,841,873 | 6,674,634 |

***Зээл I***

2003 онд Групп нь Дэлхийн Банкны Сургалтын Программын хүрээнд зээлийн удирдлагын системийг шинэчлэх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж хангамж болон зөвлөхийн үйлчилгээг багтаасан Группын байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлэх зорилгоор Сангийн Яамаар дамжуулан Дэлхийн Банктай Төслийн Гэрээг байгуулсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний Дэлхийн банкны зээлийн үлдэгдэл 57,648 ам.доллар болон 17,648 ам.доллар байна. Зээл нь жилийн 2 хувийн тогтмол хүүтэй. Үндсэн зээлийн төлбөрийг хагас жилээр хийдэг ба 2024 оны 12 дугаар сард төлбөрийн хугацаа дуусна.

***Зээл II***

Зээл II нь дараах зээлүүдээс бүрдэнэ. Үүнд:

(a) 2006 онд Групп нь Дэлхийн Банктай Охин компанийн зээлийн гэрээг байгуулсан. Энэхүү гэрээгээр Групп нь 4,000,000 хүртлэх ам.долларыг зээлэх боломжтой бөгөөд гэрээг Сангийн Яамаар дамжуулан байгуулж зээл авсан ба зээлийг Хоёрдогч хувийн секторын хөгжлийн төслийг санхүүжүүлэн дахин зээлдүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас авсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл 2,897,219 ам.доллар болон 1,867,192 ам.доллар байна. Дэлхийн Банкны энэхүү зээлийн хүү нь Лондонгийн Банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1 хувийг нэмсэнтэй тэнцүү (2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1.54%) байна. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь зээлдэгчдэд олгосон зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

(b) Дээрхи гэрээний дагуу Групп нь төгрөг зэргийг оруулан дурын валютаар 6,250,000 зээлжих тусгай эрх хүртлэх зээлийг авах боломжтой ба зээлийг тодорхой хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэхийн тулд дахин зээлдүүлэх зорилгоор Сангийн Яамаар дамжуулан авсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл 2,178 мянган ам.доллар болон 1,877 мянган ам.доллар байна.

17. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

***Зээл II (үргэлжлэл)***

Энэхүү зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаагүй хадгаламжийн өмнөх 12 сарын хугацааны дундаж хүүгээр тодорхойлогдоно (2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 6.18%). Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь зээлдэгчдэд олгосон зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

(c) 2006 онд Групп нь Дэлхийн Банкны Сургалтын Программын хүрээнд эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалт, эрсдлийн үнэлгээ болон зээлийн дүн шинжилгээ хийх ажилчдад зориулсан сургалтыг багтаасан Группын байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлэх зорилгоор Сангийн Яамаар дамжуулан Дэлхийн Банкаас 300,000 ам.долларын зээлийг авсан. 2011 болон 2012 оын 12 дугаар сарын 31-ний Дэлхийн банкны зээлийн үлдэгдэл 265,212 ам.доллар болон 245,151 ам.доллар байна. Уг зээл нь жилийн 2 хувийн тогтмол хүүтэй бөгөөд үндсэн зээлийн төлбөрийг хагас жилээр хийдэг ба зээлийн хугацаа 2025 оны 5 дугаар сард дуусна.

**Азийн Хөгжлийн Банкны зээл**

Азийн Хөгжлийн Банкны зээлүүд нь дараах зээлээс бүрдэж байна. Үүнд:

(a) 1999 онд Группын нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг шинэчлэх зорилгоор Монголбанкаар дамжуулан Азийн хөгжлийн банкнаас 134,164 ам.долларын зээл авсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний зээлийн үлдэгдэл 89,442 ам.доллар болон 84,970 ам.доллар байна. Уг зээл нь 2031 онд төлөгдөж дуусах ба жилийн 1 хувийн тогтмол хүүтэй бөгөөд 30 жилийн хугацаанд хэсэгчилсэн байдлаар төлөх нөхцөлтэй ба 2002 оноос төлбөр төлөгдөж эхэлсэн.

(b) 2011 онд Групп нь үнэ үнийн хэлхээг хөгжүүлэх дэд төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа, ажил үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээний худалдан авалтанд санхүүжилт шаардлагатай байгаа хэрэглэгчдэд зээл олгохоор Сангийн яамаар дамжуулан Азийн хөгжлийн банкнаас 11,000,000 ам.доллар хүртлэх хэмжээний зээлийг авахаар Санхүүгийн гэрээ Азийн хөгжлийн банктай байгуулсан. Уг давхар зээл нь 2018 оны 6 дугаар сард дуусах бөгөөд жилийн 12 хувийн тогтмол хүүтэй. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь зээлдэгчдэд олгосон зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

(c) Дээр тодорхойлсон Санхүүгийн гэрээний дагуу Групп нь төгрөгийн зээл авч болно. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи төгрөгийн зээлийн үлдэгдэл 1,400 мянган төгрөг байна.

## 17. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

### Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээл

Групп нь Норвегийн Банкны Ресурс Лимитед (НБР)-тэй байгуулсан банкыг шаардлагатай мэдлэг, техникийн ур чадварыг хангах үүрэг хүлээсэн Twinning Agreement гэрээг санхүүжүүлэх зорилгоор 600,000 ам.долларын зээлийн Олон Улсын Хөгжлийн Ассоциациас 1998 онд авсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи зээлийн үлдэгдэл 537,737 ам.доллар болон 525,737 ам.доллар байна. Уг зээл нь жилийн 1 хувийн хүүтэй ба зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг 2007 оны 8 дугаар сараас хийж эхэлсэн бөгөөд эцсийн төлбөр нь 2037 оны 2 дугаар сард хийгдэнэ.

### Солонгос Улсын Экспорт-Импортын Банк

2004 онд Групп нь Солонгос улсын Экспорт-Импортын банктай экспортын зээлийн гэрээг байгуулсан ба уг гэрээний хүрээнд 2,000,000 ам.долларыг Солонгос улсын экспортлогчдоос бараа, үйлчилгээ худалдан авагчдыг санхүүжүүлэх зорилгоор тэдэнд дамжуулан зээлдүүлнэ. 2011 оны 4 дүгээр сараас зээлийн дээд хэмжээ нь 20,000,000 ам.доллар болж өссөн. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шугамын зээлийн үлдэгдэл 12,958,297 ам.доллар болон 15,914,691 ам.доллар байна. Зээлийн шугамыг 2012 оны 7 дугаар сар хүртэл ашиглах боломжтой ба зээлийн хүүгийн хэмжээг зээл авах бүрт Экспорт-Импортын Банк харилцан адилгүй тогтоодог. Зээлийн үндсэн төлбөрийг санхүүгийн жилийн эцэст төлдөг.

2012 оны 7 дугаар сард Групп нь Экспорт-Импортын Банктай 20,000,000 ам.доллараас 30,000,000 ам.доллар хүртэл өсгөх нөхцөлтэйгээр Банк Хоорондын Экспортын Зээлийн гэрээг шинэчлэсэн. Шинэчлэгдсэн зээлийн шугамын хугацаа 2014 оны 7 дугаар сард дуусна.

### Австрийн Ви Ти Би Банкны зээл

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---:|---:|
| Эрсдлийн оролцоо I | - | 1,675,644 |
| Эрсдлийн оролцоо II | - | 20,945,550 |
| Эрсдлийн оролцоо V | - | 13,963,700 |
| Эрсдлийн оролцоо IV | 10,440,750 | 13,963,700 |
| | 10,440,750 | 50,548,594 |

17. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

**Австрийн Ви Ти Би Банкны зээл (үргэлжлэл)**

Групп болон Австрийн Ви Ти Би нь хамтын санхүүжилтийн гэрээг байгуулсан ба Ви Ти Бигийн зээлийг бусад зээлдэгчдэд олгосон. Хамтын санхүүжилтийн гэрээнд заасан нөхцлийн дагуу Ви Ти Би нь зээлдэгч төлбөрөө төлөх боломжгүй болсон тохиолдолд гарах алдагдлыг Групп-ээс нэхэмжлэх эрхгүй ба эрсдлийг бүрэн хүлээх ёстой. Зээлийн хүү нь жилийн тогтмол 8-аас 9 хувь байна.

**БНХАУ-ын Экспорт-Импортын Банкны зээл (ТЭКСИМ)**

2004 онд Групп нь БНХАУ-ын ТЭКСИМ Банктай зээлийн гэрээ байгуулж, уг гэрээний хүрээнд Тайван улсын экспортлогчдоос бараа материал худалдан авагчид, харилцагчдын зээлийг санхүүжүүлэх зорилгоор 6,000,000 ам.долларын зээл авах боломжтой болсон. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 106,073 ам.доллар болон 499,108 ам.доллар байна. Энэхүү зээлийн хүү нь Лондонгийн Банк хоорондын захын 6 сарын хугацаатай ам долларын (LIBOR) зээлийн хүү дээр жилийн 1.25 хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Зээлийн гэрээ нь 2014 оны 1 дүгээр сар хүртэл сунгагдсан.

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн зээл (ЯОУХАА)**

ЯОУХАА-ны зээл дараах зээлээс бүрдэж байна:

(a) Групп нь 2006 онд ЯОУХАА-тай санхүүгийн зээлийн гэрээг байгуулсан ба уг гэрээний дагуу 2,981,000,000 иентэй тэнцэх хэмжээний төгрөгийн болон ам.долларын зээлийг Жижиг, Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх болон Байгаль Орчныг Хамгаалах Хөтөлбөрийн хүрээнд ЯОУХАА-наас авсан зээлийн зарим хэсгийг ашиглах зорилгоор Монгол Улсын Сангийн Яамтай хамтран байгуулсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шугамын зээлийн үлдэгдэл 377,000 ам.доллар болон 352,500 ам.доллар байна. Зээлийн хугацаа 2019 оны 3 дугаар сард дуусах ба зээлийн хүү нь Лондонгийн банк хоорондын 6-н сарын хугацаатай ам.долларын хадгаламжийн хүү (LIBOR) дээр нэг (1%) хувийн шимтгэл нэмсэнтэй тэнцүү хувьсах хүү төлнө (2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1.7% байна). Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь зээлдэгчдэд олгосон зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

(b) Дээрхи зээлийн гэрээний дагуу авсан төгрөгийн зээлийн үлдэгдэл нь 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,179 сая төгрөг болон 878 сая төгрөг байна. Төгрөгийн зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаагүй хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж байна. (2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4% байна)

## 17. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн зээл (ЯОУХАА) (үргэлжлэл)**

(c) Групп нь 2011 онд ЯОУХАА-тай санхүүгийн зээлийн гэрээг дахин байгуулсан ба уг гэрээний дагуу 5,000,000,000 иентэй тэнцэх хэмжээний төгрөгийн болон ам.долларын зээлийг Жижиг, Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх болон Байгаль Орчныг Хамгаалах Хөтөлбөрийн хоёрдугаар хэсгийн хүрээнд ЯОУХАА-аас авсан зээлийн зарим хэсгийг ашиглах зорилгоор Монгол Улсын Сангийн Яамаар дамжуулан байгуулсан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төгрөгийн зээлийн үлдэгдэл 14,382 сая төгрөг болон 930,000 ам.доллар байна. Зээлийн дуусах хугацаа 2022 оны 11 дүгээр сар ба зээлийн хүү нь Монголбанкнаас зарласан төгрөгийн хугацаагүй хадгаламжийн өмнөх 12 сарын хүүгийн дундаж байна. (2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төгрөгөөр 4% болон ам.доллароор 1.7% байна). Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь зээлдэгчдэд олгосон зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

**Атлантик Банкны зээл**

2009 онд Групп нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хэрэглэгчдийн зээлийг санхүүжүүлэх зорилгоор Атлантик Банктай зээлийн гэрээг байгуулсан. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний зээлийн үлдэгдэл 2,338,500 ам.доллар болон 3,245,978 ам.доллар байна. Зээлийн хугацаа 2014 оны 2 дугаар сард дуусна. Зээлийн хүүг хагас жил тутам төлөх ба үндсэн төлбөрийн хугацааны эцэст төлнө.

**Жижиг, Дунд Үйлдвэрийг Дэмжих Сангийн зээл**

Жижиг, Дунд Үйлдвэрийг Дэмжих Сангийн зээл дараах зээлээс бүрдэж байна:

(a) Групп нь 2009 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яамтай шугамын зээлийн гэрээ байгуулсан. Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яам нь энэхүү зээлэнд зориулж 30 тэрбум төгрөгийг төсөвлөсөн ба нийт Монголын арилжааны банкуудад олгох ба олгох зээлийн тодорхой дүнг банк тус бүрээр тогтоогоогүй байна. 2010 болон 2011 онд Групп уг зээлийн гэрээг шинэчилсэн бөгөөд нийт төсөвийг 2010 онд 60 тэрбум төгрөг, 2011 онд 150 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн. Энэхүү зээл нь 2016 оны 6 сард дуусах ба жилийн 7 хувийн хүүтэй ба зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь зээлдэгчдэд зээл олгосон өдрөөсөө хамааран харилцан адилгүй байна. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл нь 20,471 сая төгрөг болон 19,318 сая төгрөг байна.

## 17. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

### Жижиг, Дунд Үйлдвэрийг Дэмжих Сангийн зээл (үргэлжлэл)

(b) 2011 оны 10 дугаар сард Групп нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамтай 2 дахь гэрээг ноос, ноолуурын салбарыг хөгжүүлэх зорилгоор зээлийн шугамын гэрээг байгуулсан. Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яам нь энэхүү зээлэнд зориулж 150 тэрбум төгрөгийг төсөвлөсөн ба зээл нь 2016 оны 10 дугаар сард дуусах ба зээл нь жилийн 7 хувийн хүүтэй ба зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь зээлдэгчдэд зээл олгосон өдрөөсөө хамааран харилцан адилгүй байна. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл нь 52,139 сая төгрөг байна.

### Коммерз банк

2011 онд Групп нь Коммерз банктай Худалдааны санхүүжилтийн мастер гэрээг байгуулсан ба гэрээний зорилго нь импорт болон экспортын ажил гүйлгээг санхүүжүүлэхээр хэрэглэгчдэд дамжуулан зээлдүүлэх явдал юм. Зээлийн хэмжээ, зээл авах валют, хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөгдөх огноо болон бусад нөхцөлүүд нь Групп болон хэрэглэгчийн хувьд тухай бүр нь харилцан тохиролцоно. Энэ гэрээний хүрээнд авсан ам.долларын зээлийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,329,368 ам.доллар бөгөөд зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2013 оны 1 дүгээр сар болон 2 дугаар сар байна.

### Industrial and Commercial Bank of China (“ICBC”)

2012 онд Групп нь Industrial and Commercial Bank of China-аас 4,396,868 ам.долларын зээлийг БНХАУ-аас импортлох, импортыг дэмжих зорилгоор авсан. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2013 оны 6 дугаар сар ба зээлийн хүү нь БНХАУ-ын төв банкаар тухай бүр тодорхойлогдоно.

### Ай Эн Жи Банк

2011 онд Групп нь Ай Эн Жи Банкнаас 15,000,000 еврогийн худалдааны санхүүгийн шугамын зээлийг дамжуулан зээлдүүлэх зорилготойгоор авсан. Дүн болон валютын төрлийг тогтоох мөн хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцөлүүдийг групп нь тухайн үйлчлүүлэгчийн үндсэн нөхцлийг харгалзан тохиролцоно. Энэхүү гэрээний дагуу 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх зээлийн үлдэгдэл 607,530 ам.доллар болон 4,306,770 ам.доллор байна. Зээлийн хугацаа 2013 оны 4 дүгээр сард дуусна.

17. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

**Баошанг банк**

Групп нь Баошанг банктай олон төрлийн санхүүгийн зээлийн гэрээг байгуулсан ба Баошанг банкны зээлийг бусад зээлдэгчдэд олгоно. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дараах зээлүүд байна. Үүнд:

(a) Корпорацийг хэрэглэгчдэд олгосон 720,036 ам.долларын зээл байна. Зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь зээлдэгчдэд зээл олгосон өдрөөсөө хамааран харилцан адилгүй байна.

(b) Групп нь 4,074,272 юанийн зээл авсан ба зээл 2013 оны 5 дугаар сард төлөгдөнө.

**Монголын Ипотекийн Корпорацийн зээл**

Өмнөх онуудад Групп нь тодорхой ипотекийн зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци ХХК (цаашид МИК гэх )-д буцаан солих нөхцөлтэйгээр шилжүүлсэн ба шилжүүлсэн зээлээс үүсэх эрсдэл ба өгөөжийг МИК-д шилжүүлээгүй тул уг шилжүүлсэн зээл нь бүртгэлээс хасах шалгуурыг хангаагүй гэж үзсэн. Иймээс Групп нь эдгээр гүйлгээг барьцаатай зээллэг гэж бүртгэсэн. Эдгээр ажил гүйлгээний тухай Тодруулга 7-с үзнэ үү. 2009 оноос хойш МИК-д шилжүүлсэн ипотекийн зээл байхгүй.

**Сумитомо Мицуй Банкны Корпорацийн зээл (СМБК)**

Групп нь СМБК-тэй 15,000,000 ам.доллар хүртэлх Зээлийн Санхүүжилтийн гэрээг 2012 оны 3 дугаар сард байгуулсан. Эргэн төлөлтийн хугацаа болон хүүгийн түвшин нь зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна.

**Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани (ФМО)**

Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компанийн зээл дараах зээлээс бүрдэж байна:

(a) 2012 оны 6 дугаар сард Групп нь ФМО-тэй жижиг болон дунд үйлдвэрлэл байгууллагуудыг санхүүжүүлэх зорилготойгоор 10,000,000 ам.доллар хүртэлх Сениор нөхцөлтэй зээлийн гэрээг байгуулсан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ам.долларын зээлийн үлдэгдэл нь 10,000,000 ам.доллар байна. Групп нь тогтмол болон хувьсах хүүгийн түвшинг сонгох боломтой. Уг зээлийн эргэн төлөгдөх сүүлийн хугацаа нь 2018 оны 6 дугаар сар ба хагас жилээр төлнө.

17. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

**Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани (ФМО) (үргэлжлэл)**

(b) 2012 оны 6 дугаар сард Групп нь ФМО-тэй 10,000,000 ам.доллар хүртэлх Хоёрдогч нөхцөлтэй гэрээг байгуулсан. Уг гэрээг Төв банкаар батлуулах ёстой ба хоёрдогч нөхцөлтэй гэрээний заалтын дагуу Групп нь 2 дугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөр авч үзнэ. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл нь 10,000,000 ам.доллар байна. Групп нь тогтмол болон хувьсах хүүгийн түвшинг сонгох боломтой. Уг зээлийн эргэн төлөгдөх сүүлийн хугацаа нь 2017 оны 6 дугаар сар.

**Bank of China (Хонг Конг)**

Групп нь Хонг Конгийн Bank of China-тай Богино хугацааны Арилжааг Санхүүжүүлэх нөхцөлтэй гэрээг 2012 оны 3 дугаар сард байгуулсан. Эргэн төлөлтийн хугацаа болон хүүгийн түвшин нь зээлийн хугацаанаас хамааран харилцан адилгүй байна. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Групп нь нийт 395,360 ам.долларын зээлийг авсан ба өөр өөр корпорацийн хэрэглэгчдэд зээлдүүлсэн.

**Монголын Хөрөнгийн Бирж**

Групп нь Монголын арилжааны банкуудын оролцоотойгоор Монголын Хөрөнгийн Биржэд Хамтарсан Санхүүжилтийн зээллэгийг зохион байгуулсан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Групп нь уг нөхцөлийн дагуу дараах зээлүүдийг зохион байгуулсан байна:

(a) Нийт арилжааны банкуудийн зээлийн дүн нь 1,180,704 ам.доллар байна.

(b) Энэ зээлийн дуусах хугацаа нь 2014 оны 5 дугаар сар ба жилийн 6.5 хувийн тогтмол хүүтэй байна.

**Чайна Трэйд Солушнс**

Групп нь Чайна Трэйд Солушнс-тэй Богино хугацааны Арилжааг Санхүүжүүлэх нөхцөлтэй гэрээг 2012 оны 12 дугаар сард байгуулсан. Дүн болон валютын төрлийг тогтоох мөн хүүгийн түвшин, олгох огноо, эргэн төлөлтийн огноо болон бусад нөхцөлүүдийг групп нь тухайн үйлчлүүлэгчийн үндсэн нөхцлийг харгалзан тохиролцоно. Зээлийн хугацаа 2013 оны 5 дугаар сард дуусна.

## 17. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

**Монголбанкны дэд төсөл**

Групп нь Монголын Засгийн Газар болон Монголбанк хоорондын дэд хөтөлбөр болох "Өргөн хэрэглээний бараа ба бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" зээлийн гэрээг 2012 оны 12 дугаар сард байгуулсан. Уг дэд хөтөлбөрийн хүрээнд шатахуун болон нефть бүтээгдэхүүнийг импортлох болон үр тариа ба махан бүтээгдэхүүн бэлтгэх зорилгоор Шунхлай ХХК, Магнай Трейд ХХК, Баатарууд тэнгэр ХХК болон Улаабаатар гурил ХХК-ууд зээл авсан. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкны зээлийн үлдэгдэл нь 52,730,928 төгрөг байна. Зээлийн хугацаа 2012 оны 12 дугаар сар ба жилийн 0.89 хувийн тогтмол хүүтэй байна.

**Стандарт Чартеред Банк**

Групп нь Монголын алт үйлдвэрлэгчдэд зээлдүүлэх зорилготойгоор Стандарт Чартеред Банк-тай 5,000,000 ам.долларын зээлийн гэрээг 2012 оны 5 дугаар сард байгуулсан. Зээлийн хугацаа 2013 оны 5 дугаар сард дуусна.

## 18. ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Гаргасан өрийн бичиг, хорогдуулсан өртгөөр | 600,525,865 | 207,134,041 |

Групп нь 2010 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хэрэгжиж эхлэсэн 300,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн бичиг (ЕДХӨБ) хөтөлбөрийн хүрээнд 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 150,000,000 ам.долларын сениор бондыг нэрлэсэн үнийн 99.353 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байна. Эдгээр бонд нь жилийн 8.5 хувийн хүүтэй ба хүүг хагас жил тутамд төлнө. Татварыг давхардуулж ногдуулахгүй байх тухай Монгол Улс, Сингапур Улс хоорондын хэлэлцээрийн дагуу Групп нь хөрөнгө оруулагчдад төлсөн бондын хүүд 5 хувийн татвар ноогдуулж, суутган төлөх үүрэгтэй ба ийнхүү төлж буй татварын төлбөр нь бодит хүүний хувийг нэмэгдүүлж байна.

Групп нь 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хэрэгжиж эхлэсэн 700,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн бичиг (ЕДХӨБ) хөтөлбөрийн хүрээнд 2012 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 300,000,000 ам.долларын сениор бондыг нэрлэсэн үнийн 99.676 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2015 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр байна. Эдгээр бонд нь жилийн 8.5 хувийн хүүтэй ба хүүг хагас жил тутамд төлнө.

2011 болон 2012 оны тайлант жилүүдэд өрийн үнэт цаасны дансны үнэ нь бодит хүүгийн аргаар тооцоход 891,301 мянган төгрөг ба 1,575,241 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болно.

## 19. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Хоёрдогч өглөг, хорогдуулсан өртөгөөр | 55,528,846 | 41,693,522 |

2010 оны 10 дугаар сарын 09-ний өдөр эхэлсэн 300,000,000 ам.долларын Евро Дунд Хугацааны Өрийн бичиг (ЕДХӨБ) хөтөлбөрийн хүрээнд Групп нь 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 25,000,000 ам.долларын хоёрдогч өглөгийг нэрлэсэн үнийн 99.999 хувиар гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байна. 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдөр болон 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Групп нь нэмэлт 5,000,000 ам.доллар болон 10,000,000 ам.долларын хоёрдогч өглөгийг нэрлэсэн үнээр нь гаргасан ба эргэн төлөгдөх хугацаа нь 2016 оны 5 дугаар сарын 25-ны өдөр болон 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдөр ба хагас жилээр төлнө.

## 19. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ (үргэлжлэл)

Давхар татварын тухай Монгол Улс, Сингапур Улс хоорондын хэлэлцээрийн дагуу Групп нь хөрөнгө оруулагчдад төлсөн хүүд 5 хувийн татвар ноогдуулж, суутган төлөх үүрэгтэй ба ийнхүү төлж буй татварын төлбөр нь бодит хүүний хувийг нэмэгдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа зогсоовол үнэт цаас гаргагчийн хадгаламж эзэмшигчид болон бусад өрийг барагдуулсны дараа хоёрдогч өглөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

2011 болон 2012 оны тайлант жилүүдэд хоёрдогч өглөгийн дансны үнэ нь бодит хүүгийн аргаар тооцоход 33,091 мянган төгрөг болон 40,596 мянган төгрөгөөр нэмэгдсэн болно.

## 20. БУСАД ӨР ТӨЛБӨР

| | 2012 Мян.төг | 2011 Мян.төг |
|---|---|---|
| Хуримтлагдсан хүүгийн өглөг | 37,219,386 | 23,199,760 |
| Клирингийн саатал | 16,023,299 | 14,215,203 |
| СПОТ арилжааны өглөг | 65,414,600 | 30,691,100 |
| Бусад өглөг | 9,738,657 | 4,290,684 |
| Ноогдол ашгийн өглөг | 365,945 | 365,945 |
| | 128,761,887 | 72,762,692 |

## 21. ХУВЬЦААТ КАПИТАЛ

| | Энгийн хувьцааны тоо | | 2012 | 2011 |
|---|---|---|---|---|
| | 2012 | 2011 | Мян.төг | Мян.төг |
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 3,305,056 | 3,305,056 | 16,525,280 | 6,610,113 |
| Нэмж гаргасан | - | - | - | - |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 3,305,056 | 3,305,056 | 16,525,280 | 6,610,113 |

Групп 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт зөвшөөрөгдсөн 4,000,000 ширхэг хувьцаанаас 3,305,056 ширхэг хувьцаа эргэлтэнд байна. 2012 онд Групп нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 5,000 төгрөг болгож өсгөсөн. Гаргасан бүх хувьцааны төлбөр бүрэн төлөгдсөн ба 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгжийн нэрлэсэн үнэ 2,000 төгрөг ба 5,000 төгрөг байна.

## 22. ХАЛААСНЫ ХУВЬЦАА

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 6,001,872 | 6,001,872 |
| Худалдсан | (3,381,246) | - |
| 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл | 2,620,626 | 6,001,872 |

2012 оны 2 дугаар сард Групп нь халаасны хувьцааг (үлдэгдэл энгийн хувьцааны 4.78 хувийг) хувийн хөрөнгө оруулагчидад худалдсан байна. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар халаасны хувьцааны үлдэгдэл нь 283,877 ширхэг хувьцаа болон 126,015 ширхэг хувьцаа буюу нийт эргэлтэнд байгаа энгийн хувьцааны 8.59 хувь болон 3.81 хувийг тус тус эзэлж байна.

## 23. ХҮҮНИЙ ОРЛОГО

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Зээл, урьдчилгаа | 189,057,696 | 108,869,075 |
| Хөрөнгө оруулалтын үнэт цаас | 19,612,388 | 29,252,203 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 3,633,885 | 4,559,357 |
| Буцаан худалдах гэрээгээр авсан үнэт цаас | 345,715 | 133,183 |
| Хоёрдогч зээл | 685,431 | 686,663 |
| | 213,335,115 | 143,500,481 |

## 24. ХҮҮНИЙ ЗАРДАЛ

| | **2012 Мян.төг** | **2011 Мян.төг** |
|---|---|---|
| Хадгаламж | 84,561,895 | 68,489,599 |
| Авсан зээл, эх үүсвэр | 8,354,075 | 4,059,540 |
| Буцаан худалдан авах гэрээгээр худалдсан үнэт цаас | 8,480,522 | 1,128,593 |
| Гаргасан өрийн бичиг | 30,177,065 | 17,052,569 |
| Хоёрдогч өглөг | 5,858,641 | 4,628,760 |
| | 137,432,198 | 95,359,061 |

## 25. ШИМТГЭЛ, ХУРААМЖИЙН ЦЭВЭР ОРЛОГО

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| **Шимтгэл, хураамжийн орлого** | | |
| Банкны шилжүүлэг | 4,731,504 | 3,742,399 |
| Картын үйлчилгээ | 5,561,809 | 3,385,622 |
| Зээлийн үйлчилгээ | 7,136,229 | 5,575,020 |
| Бусад | 1,037,807 | 543,779 |
| Шимтгэл, хураамжийн орлогын дүн | 18,467,349 | 13,246,820 |
| **Шимтгэл, хураамжийн зардал** | | |
| Картын үйлчилгээний зардал | 1,446,489 | 915,184 |
| Бусад | 621,337 | 197,403 |
| Шимтгэл, хураамжийн зардлын дүн | 2,067,826 | 1,112,587 |
| **Шимтгэл, хураамжийн цэвэр орлого** | 16,399,523 | 12,134,233 |

## 26. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО (ЦЭВЭР)

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| Ханшийн тэгшитгэлийн олз (цэвэр) | 12,845,020 | 13,339,291 |
| Үнэт металлын арилжааны олз (цэвэр) | 649,390 | 705,834 |
| Бусад | 808,700 | 131,091 |
| | 14,303,110 | 14,176,216 |

## 27. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| Боловсон хүчний зардал | 16,475,250 | 8,939,306 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 10) | 2,441,789 | 1,731,867 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тодруулга 11) | 321,884 | 486,832 |
| Зар сурталчилгааны зардал | 2,686,396 | 1,114,943 |
| Түрээсийн зардал | 2,390,011 | 1,700,901 |
| Мэргэжлийн үйлчилгээний хөлс | 1,327,080 | 393,122 |
| Техникийн туслалцаа болон гадаадын банкны гуйвуулгын шимтгэл | 988,841 | 720,837 |
| Данснаас хассан үндсэн хөрөнгө | 34,435 | 302 |
| Даатгалын зардал | 74,795 | 166,598 |
| Албан томилолт | 553,585 | 623,795 |
| Бэлэн мөнгө цуглуулах зардал | 805,856 | 499,742 |
| Бичиг хэргийн зардал | 552,100 | 505,928 |
| Харилцаа холбооны зардал | 790,369 | 678,238 |
| Сургалтын зардал | 329,383 | 129,794 |
| Ашиглалтын зардал | 351,166 | 239,790 |
| Засвар үйлчилгээний зардал | 314,438 | 439,098 |
| Харуул, хамгаалалтын зардал | 119,301 | 96,956 |
| Зочин төлөөлөгчийн зардал | 483,433 | 247,317 |
| Тээврийн зардал | 278,900 | 219,940 |
| Мэдээлэл технологийн засвар үйлчилгээ | 800,034 | 608,708 |
| Бусад (*) | 756,522 | 527,437 |
| | 32,875,568 | 20,071,451 |

(*) Бусад үйл ажиллагааны зардалд зээл барагдуулахтай холбоотой зардал, цэвэрлэгээ болон удирдлагын бусад нэмэгдэл зардал орно.

## 28. ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН (АЛДАГДАЛ) БА НӨХӨЛТ

| | 2012<br>Мян.төг | 2011<br>Мян.төг |
|---|---|---|
| Зээлийн болзошгүй эрсдлийн (зардал), нөхөлт | 4,305,103 | (3,976,213) |
| Бусад хөрөнгө болон өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын нөхөлт | 2,249,333 | 905,348 |
| | 6,554,436 | (3,070,865) |

## 29. ТҮРЭЭС

Групп нь зарим салбар, нэгжийн оффисын байр болон комьпютерийг төрөл бүрийн түрээсийн гэрээгээр түрээсэлдэг. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэг жилээс дээш хугацаатай, гэрээг цуцлах боломжгүй үйл ажиллагааны түрээсийн гэрээгээр түрээсэлсэн түрээсийн батлан даалт дараах байдалтай байна.

| | 2012 Мян.төг | 2011 Мян.төг |
|---|---|---|
| Нэг жилийн доторхи | 1,911,179 | 1,504,534 |
| 1-5 жил | 2,944,352 | 2,514,774 |
| Түүнээс дээш | - | - |
| | 4,855,531 | 4,019,308 |

## 30. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

**Нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан:**

| | 2012 Мян.төг | 2011 Мян.төг |
|---|---|---|
| Орлогын татварын зардал – тайлант жил | 14,817,338 | 9,212,154 |
| Орлогын татварын зардал – өмнөх жилийн залруулга | - | 70,523 |
| | 14,817,338 | 9,282,677 |

**Орлогын албан татварын зардлын тохируулга:**

| | 2012 Мян.төг | 2011 Мян.төг |
|---|---|---|
| Татварын өмнөх ашиг | 77,944,062 | 51,384,508 |
| Ноогдуулсан орлогын албан татвар 25% | 19,486,016 | 12,846,127 |
| ТНО-с хасагдахгүй зардалд ногдох татвар | 261,803 | 161,476 |
| Татвар ногдохгүй орлогод ногдох татвар | (4,419,312) | (3,262,224) |
| 10 хувиар тооцох ТНО-с тооцсон татвар | (450,000) | (450,000) |
| Өмнөх жилийн татварын залруулга | - | 70,523 |
| Бусад | (61,169) | (83,225) |
| Орлогын татварын зардал | 14,817,338 | 9,282,677 |

## 30. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (үргэлжлэл)

Групп нь Монгол Улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн дагуу 3 тэрбум хүртэлх төгрөгийн татвар ногдуулах орлогод 10%-ийн татвар, 3 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300 сая төгрөг дээр 3 тэрбумаас давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж татвар ноогдуулж, төлөх үүрэгтэй.

## 31. НООГДОЛ АШИГ

Групп 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлангийн жилд ноогдол ашиг зарлаагүй болно.

## 32. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан дах мөнгө түүнтэй адилтгах зүйлс нь касс дах бэлэн мөнгө болон ямар нэгэн хязгаарлалт хийгдээгүй төлбөр гүйцэтгэхэд бэлэн бусад банк санхүүгийн байгууллага дах харилцах дансанд байршуулсан 3 сар хүртлэх хугацаатай мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ. 2011 болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан мөнгө, түүнтэй адилтгах зүйлс дараах байдалтай байна.

| | **2012<br>Мян.төг** | **2011<br>Мян.төг** |
|---|---|---|
| Мөнгө, банкинд байршуулсан мөнгө | 444,813,254 | 474,964,634 |
| Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага | - | (3,613,520) |
| Заавал байлгах нөөц | (250,535,821) | (168,064,650) |
| Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс | 194,277,433 | 303,286,464 |

## 33. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Сегментийн мэдээллийг Группын бизнесийн сегментэд үндэслэн тайлагнасан. Групп нь тайлангийн загвар болон бизнесийн сегментийг Группын удирдлагын ба дотоод тайлангийн бүтэц зохион байгуулалтад үндэслэн тодорхойлдог.

Хөрөнгө зохицуулалтын газар нь зах зээлийн шударга нөхцлийн дагуу бизнесийн сегментүүдэд капиталын хуваарилалт болон санхүүжилтийн өртгийг тусгахын тулд тэднээс хүү авч, хүү төлдөг.

Сегментийн капитал зардал гэж тайлант жилд, гүдвиллээс бусад биет бус хөрөнгө ба үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан нийт зардлыг хэлнэ.

## 33. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ (үргэлжлэл)

**Үйл ажиллагааны сегмент**

Группын үйл ажиллагааны сегмент нь дараах үндсэн сегментүүдээс бүрдэж байна:

| | |
|---|---|
| • *Байгууллагын банкны газар* | Байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. |
| • *Жижиг, Дунд Байгууллагын банкны газар* | Жижиг, Дунд байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. Групп нь тухайн харилцагчийн бизнесийн хэмжээнээс үл хамааран 100,000-1,000,000 ам.долларын санхүүжилт олгосон харилцагчдаа энэхүү ангилалд оруулдаг. |
| • *Жижиг буюу иргэдийн банкны газар* | Карт эзэмшигчдийн карт, иргэдийн харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнээс бүрдэнэ. |
| • *Гадаад харилцаа, Хөрөнгө оруулалтын байгуулагын газар* | Группын санхүүгийн үйл ажиллагаа болон арилжааны ажил гүйлгээнээс бүрдэнэ. |
| • *Хөрөнгө зохицуулалтын газар* | Зээл авах, өрийн бичиг гаргах, эрсдлийн удирдлагын зорилгоор дерватив хэрэгсэл хэрэглэх, богино хугацаат хадгаламж хийх, засгийн газрын болон компанийн өрийн бичиг зэрэг түргэн хөрвөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх зэргээр Группын санхүүжилт, эрсдлийн төвлөрсөн удирдлагаар хангах үүрэгтэй. |
| • *Бусад* | Төв оффисын үйл ажиллагаа болон арын албаны үйлчилгээний хэсгийн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Энэ нь Группын үл хөдлөх хөрөнгө болон холбогдох тогтмол гардаг нэгдсэн зардлуудыг хянаж, зохицуулдаг. |

## 33. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ (үргэлжлэл)

***(Мянган төгрөгөөр )***

| **2012 оны 12-р сарын 31-ний байдлаар** | **Байгууллагын банкны газар** | **Жижиг, Дунд байгууллагын газар** | **Иргэдийн банкны газар** | **Гадаад харилцаа, Хөрөнгө оруулалтын банкны газар** | **Хөрөнгө оруулалт** | **Бусад** | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| Сегментийн үр дүн: | | | | | | | |
| Гадаад орлого | | | | | | | |
| Цэвэр хүүгийн орлого (зардал) | 112,750,763 | 11,908,490 | (9,451,651) | (30,178,128) | 713,000 | (9,839,557) | 75,902,917 |
| Хураамж, шимтгэлийн цэвэр орлого | 5,263,310 | 86,916 | 10,216,153 | 14,366 | 169,889 | 648,889 | 16,399,523 |
